

## ГАРЧИГ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

- 1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн талаар ..... 2
- 1.2 "Нэг хот-нэг стандарт" жилийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ..... 3

### ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 2.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30-р тогтоол, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тушаал, 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108, мөн НЗД-ын А/62, А/102, А/166, А/174 дүгээр захирамжуудын хэрэгжилтийн талаар ..... 4
- 2.2 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн талаар .... 6

### ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- 3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилтийн мэдээлэл: ..... 9
- 3.1.1 Техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, нийтийн тээврийн үйлчилгээг тасалдалгүй явуулах ажлын хүрээнд ..... 9
- 3.2. Барилга байгууламжийн засвар үйлчилгээний ажлын хүрээнд ..... 16
- 3.3 Байгууллагын хөдөлмөр аюулгүй ажиллагааны хууль дүрмийн хүрээнд зохион байгуулсан ажлын талаар: ..... 25

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- 4.1 Байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд 18
- 4.2 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй 400 автобусанд утаа бууруулагч төхөөрөмж суурилуулсан ажлын талаар ..... 32
- 4.3 Гамшгаас хамгаалах ажлын талаар ..... 37
- 4.4 Шинэ корона вирусын тархалтаас урьдчилан сэргийлэх ажлын талаар ..... 37

### ТАВДУГААР БҮЛЭГ: БУСАД МЭДЭЭЛЭЛ

- 5.1 Бусад мэдээлэл. .... 42
- 5.2 Цахилгаан автобусны ашиглалтын талаар ..... 42

### ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ ..... 56

# **“ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ” ОНӨААТҮГ-ЫН ТЕХНИКИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2020 оны 12 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Зорилго: Техникийн хэлтсийн үндсэн зорилго нь нийт хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээний технологийг мөрдөх, засвар үйлчилгээний ажлыг шуурхай оновчтой зохион байгуулах, байгууллагын барилга байгууламж, дулаан болон ил зогсоол, зам талбайн бүрэн бүтэн байдлыг хангах, цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбоо зэрэг инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангаж ажиллахад оршино.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН**

1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн талаар:

Зорилт 1.1 Нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийж, иргэдийн эрэлтэд нийцэн шинэ чиглэл бий болгоно. "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын харъяа баазын гаражийн их засвар болон агааржуулалт, засварын станцын барилгын их засварыг хийх талаар:

Нийт засвар хийх объектын тоо. гаражийн засвар 2, агааржуулалт хийх гаражийн тоо 2, станцын барилгын их засвар 1.

НЗД-ын 2020 оны А/85 тоот захирамжаар батлагдсан нийслэлийн төсвөөс эрх шилжин ирсэн НХААГ/202001244 дугаартай “Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын баазын гаражуудын их засвар, агааржуулалтын ажил” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнийн санал авах тендерт 1,498,991,405 төгрөгийн үнэ санал болгон шаардлагад нийцсэн Ди Вай Кэй Би ХХК-тай 2020 оны 08 сарын 19-нөөс гэрээ байгуулан 2020 оны 10 сарын 19 нд гүйцэтгэлийг хүлээн авахаар төлөвлөсөн байсан. 1-р гаражийн хаалга солих, хана тааз, ферм нуруу будах, шалыг бетондож, эпоксид будгаар будах ажлууд хийгдэж бусад ажлууд 2020 оны 11 дүгээр сарын 11-нээс бүх нийтийн өндөржүүлсэн байдлын зэрэг тогтоосонтой холбогдон зогссон.

Троллейбусны хэрэглээг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд шугамд их засвар хийж, засварын техник хэрэгслийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Контактын 17 км урттай шугам солих. Байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулах санал өгсөн боловч НӨАУГ-аас Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдаагүй тул ажлууд хийгдээгүй.

Цахилгаан хангамжийн лабораторийн машин 1. Байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулах санал өгөн боловч НӨАУГ-аас Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдаагүй тул ажлууд хийгдээгүй.

Зорилт 1.2 Нийтийн тээврийн хэрэгслийг байгальд ээлтэй технологид шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, эко автобус, троллейбусны хэрэглээг нэмэгдүүлэх. Нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан хөдөлгүүртэй их багтаамжийн автобусыг нэвтрүүлэх талаар:

Нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн 220 автоус, 40 троллейбусаар парк шинэчлэлт хийх саналаа НТҮГ-т хүргүүлсэн. НӨАУГ-аас Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдаагүй.

1.2 "Нэг хот-нэг стандарт" жилийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

3-р зүйл. Нийтийн тээврийн салбарт парк шинэчлэлт хийх талаар:

НЗД-ын А/178 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт болон Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 2020 оны 02 сарын 13-ны өдрийн Удирдах зөвлөлийн хуралд Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1, 2-р баазын цахилгаан хангамжийн системийг шинэчлэн сайжруулж, цахилгаан хөдөлгүүртэй автобусаар парк шинэчлэлт хийх, 10 ш цэнэглэх цэгийн ажлын зураг, төсөв хийх санал танилцуулсан. Өнөөгийн байдлаар 2-р баазын цэнэглэх цэгийн цахилгааны хэрэглээний чадлын техникийн нөхцөл гарсан, 1-р баазын нөхцөл судлагдаж байна. Бусад 8-н газрын газар эзэмших зөвшөөрөл гарсан. Шархад эцсийн буудал төвийн газрыг НТҮГ-аас шилжүүлэх болон 1 газар боломжгүй гэсэн хариуг өгсөн. Цахилгаан автобус турших асуудлаар хамтран ажиллах гэрээний дагуу байгууллага дээр 8 ш цахилгаан автобус ирсэн. 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал туршилтын хугацаанд цахилгаан автобусыг шугамын үйлчилгээнд туршсан ажлын тайланг нэгтгэн УБХХК ХХК болон НТҮГ-т хүргүүлсэн.

6-р зүйл. Автотээврийн үйлчилгээ ангилал, ерөнхий шаардлага MNS 5325. 5342. 5347 стандартын хэрэгжилтийн талаар:

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Удирдах зөвлөлийн хуралд 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд зориулан 1, 2-р баазын объектуудын их засвар, шинэчлэлтийн 17-н ажлыг хийх болон зураг, төсөв хийх санал танилцуулсан.

УБСК ХХК-ний техник тоног төхөөрөмж шинэчлэгдсэнтэй холбогдуулан Удирдлага мэдээллийн цахим тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хүрээнд баазуудын тээврийн хэрэгсэлд тоног төхөөрөмж суурилуулах зорилгоор автобусанд ашиглагдаж байгаа онлайн DVR, SD карт, 4 ш камер, түлш хэмжигч тоног төхөөрөмж, техникийн аюулгүй ажиллагааг шалган баталгаажуулах комиссыг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/19 тоот тушаалаар томилсон. 2020 оны 06 дугаар сарын 09-ны байдлаар нийт 240 тээврийн хэрэгслээс 239 тээврийн хэрэгсэлд суурилуулсан. Онлайн камер ашиглалтын гэрээг 2 тал байгуулж ажиллаж байна.

**Тусгагдсан зорилт:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт хангах.

"Нэг хот-нэг стандарт" жилийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын харъяа баазын гаражийн их засвар болон агааржуулалт, засварын станцын барилгын их засварыг хийх ажлын биелэлт 80 хувь.

Цахилгаан хангамжийн лабораторийн машин худалдан авах, контактын сүлжээний 17 км урттай шугам 17 км солихоор Байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулан батлуулах санал өгсөн. Биелэлт 100 хувь.

Нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн 220 автоус, 40 троллейбусаар парк шинэчлэлт хийх саналаа НТҮГ-т хүргүүлсэн. Биелэлт 100 хувь.

Цахилгаан тээврийн хэрэгсэлд зориулан 1, 2-р баазын цахилгаан хангамжийн системийг шинэчлэн сайжруулж, цахилгаан хөдөлгүүртэй автобусаар парк шинэчлэлт хийх, 10 ш цэнэглэх цэгийн ажлын зураг, төсөв хийх ажлууд явагдаж байна. Биелэлт 80 хувь.

2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд зориулан 1, 2-р баазын объектуудын их засвар, шинэчлэлтийн 13-н ажлыг хийх болон зураг, төсөв хийх санал Удирдах зөвлөлд танилцуулсан. 1-р гаражийн агааржуулалт, гэрэлтүүлгээс бусад засварын ажил хийгдсэн. Биелэлт 80 хувь.

УБСК ХХК-тай хамтран тээврийн хэрэгслүүдэд онлайн хяналтын тоног төхөөрөмжүүдийг суурилуулан стандарт хэрэгжилт хангуулах тал дээр хяналт тавин ажиллаж байна. Ажлын биелэлт 96 хувь.

Дундаж үнэлгээ 89,3 хувьтай байна.

**Хүрсэн үр дүн:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд хэрэгжсэнээр дулаан зогсоол, засвар үйлчилгээний байр талбайн нөхцөл сайжирч ажиллах нөхцөл дээшилсэн.

“Нэг хот-нэг стандарт” жилийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласнаар Техникийн хэлтсийн хэмжээнд цахилгаан автобусны парк шинэчлэлтэд зориулсан ажил болон их засвар шинэчлэлтийн ажлыг албадын төлөвлөгөөнд тусгаснаар графикт ажлын зохион байгуулалт тодорхой хэмжээнд дээшилж, объектийн болон тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмжийн үйл ажиллагаа сайжирсан.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30-р тогтоол, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тушаал, 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108, мөн НЗД-ын А/166, А/174, НЗД-ын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/62, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/102 дугаар захирамжуудын хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30-р тогтоол, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тушаал, 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108, А/166, А/174 дүгээр “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/62,

“Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/102 дугаар захирамжууд гарсан.

“Шинэ коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах” ажлын хүрээнд Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн дарга Д.Оюунчимэгийн 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан “Цаг агаарын хүйтрэлттэй холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага эмх цэгцийг өндөржүүлэхэд хяналт тавих хариуцлагатай эргүүл хийх хуваарь” баталсны дагуу 2020 оны 02 дугаар сарын 03 нд 20:00 цагаас 22:00 цаг хүртэл 2-р бааз дээр ээлжийн ажилтнуудын ажлын хариуцлага, оройн буултаар тээврийн хэрэгсэл угааж цэвэрлэж байгаа байдал шалгаж хариуцлагатай эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн.

2020 оны 02 дугаар сарын 26 нд 15:00 цагаас 23:00 цаг хүртэл байгууллагын ерөнхий эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэж Шинэ коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага, эмх цэгцийг өндөржүүлэхэд хяналт тавин ажиллаа. Эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэх үед 1-р бааз дээр НТҮГ-ын орлогч дарга н.Мөнхбаяр, 2-р бааз дээр НТҮГ-ын орлогч дарга н.Булгаа, Автотээврийн Улсын байцаагч Тумбааш нар тээврийн хэрэгслийн оройн буулт, цэвэрлэгээ ариутгалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын захирал Г.Төмөрбаатарын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Шинэ коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага, эмх цэгцийг өндөржүүлэхэд хяналт тавих хариуцлагатай эргүүл хийх хуваарь”-ийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 28 нд СБД-ийн 14 дүгээр хороонд МТИ Л.Мөнхдалайтай хамт 18:00 цагаас 23:00 цаг хүртэл эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн.

Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан “байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага эмх цэгцийг өндөржүүлэхэд хяналт тавих хариуцлагатай эргүүл хийх хуваарийн дагуу байгууллагын бүх албан хаагчид 2020 оны 06 сарын 30-ны өдрийг дуустал өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байна.

Байгууллагын объект ба тээврийн хэрэгслийн ариутгалыг хийж 1-р баазын үйл ажиллагааны талаар НТҮГ-ын орлогч дарга н.Мөнхбаярт, 2-р баазыг НТҮГ-ын орлогч дарга н.Булгаа нарт 7 хоногийн 5 дах өдрийн орой бүр объект, тээврийн хэрэгслийн оройн буулт, цэвэрлэгээ ариутгал хийж байгаа талаар зурагт мэдээ өгч ажиллаж байна. Энэ хугацаанд 3-н мэргэжлийн байгууллагаар 10 хоног тутамд ариутгал, халдваргүйжүүлэлтийг иж бүрнээр хийлгэж ажиллаж байна.

Нийслэлийн Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1-р баазын Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд Зорчигч тээврийн нэгтгэлийн захирлын 2020 оны 3-р сарын 23-ний өдрийн А/24 тоот тушаалаар Орон тооны бус штаб, мэргэжлийн анги томилох тухай, Зорчигч тээврийн нэгтгэлийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 1-ны А/29 тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулах тухай 1-р хавсралтаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг удирдах бүрэлдэхүүнийг, 2-р хавсралтаар албан тушаалтнуудыг шинэчлэн баталж тодотгол хийж Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргаар батлуулсан. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 2-р баазын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг 04 дүгээр сарын 03 нд тодотгон батлуулсан. 2020 оны 1дүгээр сарын 26-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 30 тоот Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх

арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж талаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар нийт ажилтан, ажилчдадаа зөвлөмж яриа таниулга хийж нийт хөдлөх бүрэлдэхүүнийг өглөө орой бүр ариутгал цэвэрлэгээ хийж, нийт ИТА нарыг хуваарь гарган өглөө орой жижүүрлэн ажиллаж, ажилтан албан хаагчдыг байнгын амны хаалт хэрэглэх, гар ариутгал хийх, тээврийн хэрэгсэлд гар ариутгагч байрлуулах, ажилтан албан хаагчдын халууныг байнга хэмжих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.

2.2 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн талаар:

13.2.7-р зүйл. Үйл ажиллагаагаа мэдээллийн технологи ашиглан цахимаар явуулах боломжийг бүрдүүлэх талаар:

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан <https://erp.ulaanbaatar.mn/> Нэгдсэн удирдлагын систем ашиглан байгууллагын ажилтнууд цахимаар ажил хийж бна, мөн ZOOM программ хангамж ашиглан цахимаар хурал уулзалтууд хийж бааз, хэлтэс албад руу үүрэг даалгавар өгч биелэлтийг шалгаж ажилласан.

2.3 УОК-ын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны тэмдэглэл №362.2. Хязгаарлалтын дэглэмийн үед иргэдийн хөдөлгөөнийг хянах зорилгоор худалдаа үйлчилгээний байгууллага, гудамж талбай, шалган нэвтрүүлэх цэг болон нийтийн тээврээр үйлчлүүлэх үед тухайн байршлыг тодорхойлсон QR кодыг уншуулж хэвшүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар:

НЗД-ын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 02-04/6486 тоот иргэдийн зорчих хөдөлгөөнийг нарийвчлан гаргах үүднээс иргэний цахим үнэмлэхнийн QR кодыг ашиглан иргэдийн зорчилтын бүртгэлийг хянах <https://qr.ulaanbaatar.mn/> системийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан ажил зохион байгуулах гэсэн албан бичгийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн 1, 2-р баазуудад нэвтрэх хүмүүсийг иргэний үнэмлэхний QR код уншуулж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

2.4 УОК-ын 2020 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэл №373.1 Иргэд олноор үйлчлүүлдэг худалдаа үйлчилгээний газар, аж ахуйн нэгжүүдийн угтах нэвтрэх хэсэг, нийтийн тээврийн хэрэгсэл зэрэг газруудад тухайн цэг, байршлыг илэрхийлсэн тэмдэглэгээг (QR код) байршуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих талаар:

НЗД-ын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 02-04/6486 тоот албан бичгийн дагуу 1, 2-р бааз, Нэгтгэлийн байрны орох хаалганы хэсэгт иргэний цахим үнэмлэхний QR код уншуулах цэгийг байрлуулсан.

2.5 Мэргэжлийн хяналт ерөнхий газрын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 07/3159 тоот Байгууллагын цэвэрлэгээ, уйлчилгээ, халдваргүйжуулэлт хийгдэж байгаа ажилд өгсөн зөвлөмжийн талаар:

/мэргэжлийн байгууллагаар болон байгууллага өөрсдөө цэвэрлэгээ, үйлчилгээ, халдваргүйжүүлэлт хийж байгаа эсэх, хугацааны давтамж, ариутгалын бодис /спирт, агааржуулагч гэх мэт/ хүрэлцээ хангамжыг тооцох/

Ажлын байрны харуул хамгаалалтын бэлэн байдал хангагдсан эсэх талаар:

/ажлын байрны харуул хамгааллыг хэрхэн зохион байгуулж байгаа байдал /нэгдсэн харуул хамгаалалт, байгууллагаас цалинжиж байгаа харуултай эсэх/, бэлэн байдлын зэрэгтэй холбоотой ажлын байрны хамгаалалтын бэлэн байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж ажилласаныг тооцох/

Байгууллагын 1, 2-р Баазын объектуудын нэгдсэн хамгаалалтын бэлэн байдлыг хангуулахаар Шүтээн Уул ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан ба орох хаалган дээр дотогш нэвтрэх ажиллагсад, иргэдийн халууныг шалгаж нэвтрүүлж байна.

НЗД-ын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 02-04/6486 тоот иргэдийн зорчих хөдөлгөөнийг нарийвчлан гаргах үүднээс иргэний цахим үнэмлэхнийн QR кодыг ашиглан иргэдийн зорчилтын бүртгэлийг хянах <https://qr.ulaanbaatar.mn/> системийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан ажил зохион байгуулах гэсэн албан бичгийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн 1, 2-р баазуудад нэвтрэх хүмүүсийг иргэний үнэмлэхний QR код уншуулж нэвтрүүлэх ажлыг орох хаалган дээр зохион байгуулсан.

Бэлэн байдлын зэргийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн талаар:

/ Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгааг тооцох/

Нийслэлийн Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1-р баазын Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд Зорчигч тээврийн нэгтгэлийн захирлын 2020 оны 3-р сарын 23-ний өдрийн А/24 тоот тушаалаар Орон тооны бус штаб, мэргэжлийн анги томилох тухай, Зорчигч тээврийн нэгтгэлийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 1-ны А/29 тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулах тухай 1-р хавсралтаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг удирдах бүрэлдэхүүнийг, 2-р хавсралтаар албан тушаалтнуудыг шинэчлэн баталж тодотгол хийж Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргаар батлуулсан. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 2-р баазын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг 04 дүгээр сарын 03 нд тодотгон батлуулсан.

2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 1, 2-р баазын Баазуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу “Гамшгаас хамгаалах тухай хууль болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах шуурхай бүлгийн зааварчилгаа” гарган мөрдөж ажиллаж байна. Монгол Улсын засгийн газрын 178 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг Даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 тоот “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамж зэргийг хавсарган баазуудын ээлжийн инженерүүд захирамж, шийдвэрийн дагуу дагуу ажиллахыг үүрэгжүүлсэн.

2.6 Монгол Улсын Засгийн Газрын 178, 181 дугаар Шинэ коронавируст халдвар цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг хангах талаар:

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар нийт ажилтан, ажилчдадаа зөвлөмж яриа таниулга хийж нийт хөдлөх бүрэлдэхүүнийг өглөө орой бүр ариутгал цэвэрлэгээ хийж, нийт ИТА нарыг хуваарь гарган өглөө орой жижүүрлэн ажиллаж, ажилтан албан хаагчдыг байнгын амны хаалт хэрэглэх, гар ариутгал хийх, тээврийн хэрэгсэлд гар ариутгагч байрлуулах, жолооч, шалгагч нарыг зорчигчдоос

тусгаарлах хаалт хийх, хамгаалах хувцсаар хангах, ажилтан албан хаагчдын халууныг байнга хэмжих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.

**Тусгагдсан зорилт:** Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, НЗД-ын захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. Монгол Улсын Засгийн Газрын 178, 181 дугаар Шинэ коронавируст халдвар цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг хангах. Мэргэжлийн хяналт ерөнхий газрын Байгууллагын цэвэрлэгээ, уйлчилгээ, халдваргүйжуулалт хийгдэж байгаа ажилд өгсөн зөвлөмжийн

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** “Шинэ коронавируст цар тахалтай тэмцэх, халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах” ажлын хүрээнд Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн даргын “Цаг агаарын хүйтрэлттэй холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага эмх цэгцийг өндөржүүлэхэд хяналт тавих хариуцлагатай эргүүл хийх хуваарь” баталсантай холбогдуулан хуваарийн дагуу эргүүл жижүүрийн үүрэг, бусад зохион байгуулалтын ажлуудыг гүйцэтгэсэн. Биелэлт 100 хувь.

Иргэдийн зорчилтын тоог гаргах зорилгоор иргэний цахим үнэмлэхнийн QR кодыг ашиглан иргэдийн зорчилтын бүртгэлийг хянах <https://qr.ulaanbaatar.mn/> системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Биелэлт 100 хувь.

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх НЗД-ын захирамж, НОК-ийн үүрэг даалгаврын дагуу объектын ариутгал, цэвэрлэгээ болон тээврийн хэрэгслийн өглөөний гаралт, оройн буулт, цэвэрлэгээ ариутгалд байгууллагын ажиллагсад хяналт тавьж ажилласан. Биелэлт 95 хувь.

Байгууллагын 1, 2-р баазын Баазуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу “Гамшгаас хамгаалах тухай хууль болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах шуурхай бүлгийн зааварчилгаа” гарган мөрдөж ажилласан. Биелэлт 100 хувь.

Мэргэжлийн хяналт ерөнхий газрын зөвлөмжийн дагуу Байгууллагын цэвэрлэгээ, уйлчилгээ, халдваргүйжуулалт ариутгалын ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. Биелэлт 100 хувь.

Дундаж үнэлгээ 99 хувьтай байна.

**Хүрсэн үр дүн:** Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 178, 181 дугаар тогтоол, НЗД-ын үйл захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар ТТБТХ-ийн хэмжээнд эрсдлээс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага, эмх цэгцийг өндөржүүлэх ажлын зохион байгуулалт тодорхой хэмжээнд дээшилсэн.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

3.1.1 Техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, нийтийн тээврийн үйлчилгээг тасалдалгүй явуулах ажлын хүрээнд:

1-р Бааз 2020 оны байдлаар ТҮ1-ээр 414, ТҮ2-оор 464, хөдөлгүүр засварт 103, үндсэн рамын засварт 25, кузов засварт 442 автобус хамрагдаж урсгал засвараар сард дунджаар 625 автобус, нийт давхардсан тоогоор 5575 автобус засвар үйлчилгээ хийсэн. Урсгал засвараар орсон автобусны тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,31 хувиар багассан байна. Урсгал засвараар орсон автобусны тоо нь автобусны насжилт нэмэгдсэн, сэлбэг хэрэгслийн хангамж дутмаг, гүйлт өндөр байгаатай холбоотой байна. Засварын төрлүүдээр авч үзвэл хөдөлгүүрийн их засвар, хөргөлтийн систем, хийн систем, цахилгаан хэлхээний засвар нэмэгдэх хандлагатай байна.

Хүйтний улирлын үйлчилгээний хүрээнд автобусны дулаацуулах систем заалны пар, пийшин засвар, цан үлээгчийн засварлах ажил 100 хувьтай тус тус хийгдсэн ба эвдрэл гарсан тухай бүр хурдан шуурхай засварлах, стандарт мөрдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэснээр техникийн бэлэн байдлыг 92,2 хувьтай ханган ажилласан.

2-р Бааз 2020 оны байдлаар ТҮ1-ээр 455, ТҮ2-оор 568, хөдөлгүүр засварт 153, үндсэн рамын засварт 32, кузов засварт 500 автобус хамрагдаж урсгал засвараар 3190 автобус, нийт давхардсан тоогоор 5026 автобус засвар үйлчилгээ хийсэн.

Шаардлагатай сэлбэгийн захиалгыг тухай бүрт нь хангамжийн менежерт гаргаж өгч байгаа бөгөөд МА3 215 автобусны сэлбэгийн олдоц муу байгаас тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байна. Учир нь МА3 215 автобусны сэлбэгийн нийлүүлэлт хугацаандаа хийгдээгүйгээс 7 тээврийн хэрэгсэл сэлбэггүй зогсож байна.

ЦХА нь нийт 13 Татах дэд станцаас ТДС-8, 11, 12, 13-р станцуудыг ашиглалтаас чөлөөлснөөр одоогоор есөн татах дэд станц хэвийн горимоор ажиллаж байна. Нийт 48,1 км өндрийн кабелиас 35,9 км, 43,4 км намын кабелиас 25,1 км, контактын сүлжээний 50 км хос шугам, Улаанбаатар хотын хэмжээнд тус байгууллагын эзэмшлийн 2204 ш даацын тулгуур байгаагаас одоо 1477 ш даацын тулгуур ашиглагдаж байна.

2020 онд Цахилгааны найдвартай ажиллагааг хангах, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах ажлын хүрээнд контактын сүлжээ болон татах дэд станцуудад хийгдэх засваруудыг засварын үечлэл технологийн дагуу сар бүр төлөвлөгөө гарган баазын даргаар батлуулан ажилласан.

2020 онд Контактны сүлжээнд 27 удаа шугам тасарч, 205 удаагийн шугамын дуудлага хүлээн авч засвар үйлчилгээ хийж шугамын хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

#### **Техникийн бэлэн байдал ба техникийн саатлын харьцуулсан хүснэгт**

| Техникийн бэлэн байдал /%/ |               |              |                | Техникийн саатал /цаг/ |            |                |
|----------------------------|---------------|--------------|----------------|------------------------|------------|----------------|
| Баазууд                    | 2019 он       | 2020 он      | Өсөлт, бууралт | 2019 он                | 2020 он    | Өсөлт, бууралт |
| 1-р Бааз                   | 92,7%         | 92,2%        | -0.5%          | 33:45                  | 30:20      | 3:25           |
| 2-р Бааз                   | 85,2%         | 87.46%       | +2,26%         | 451:3                  | 80:40      | 371:30         |
| Нийт                       | <b>88,95%</b> | <b>89,83</b> | <b>+0,88%</b>  | <b>485:15</b>          | <b>111</b> | <b>374:15</b>  |


Нийслэлийн зорчигч тээврийн нэгтгэлийн тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлын коэффициент 2019 оны байдлаар 88,95 хувь байсан бол 2020 онд 89,83 хувь болж 0,88 хувиар дээшилсэн, техникийн сааталтай цаг 374,15 цагаар багассан үзүүлэлттэй байна.

#### **Засвар үйлчилгээний тоо хэмжээний харьцуулсан хүснэгт**

| Д/д | Засварын төрөл    | 2019 он  |          |              | 2020 он     |             |              |
|-----|-------------------|----------|----------|--------------|-------------|-------------|--------------|
|     |                   | 1-р Бааз | 2-р Бааз | Нийт         | 1-р Бааз    | 2-р Бааз    | Нийт         |
| 1   | ТҮ-I              | 417      | 472      | <b>889</b>   | 414         | 455         | <b>869</b>   |
| 2   | ТҮ-II             | 651      | 622      | <b>1273</b>  | 464         | 568         | <b>1032</b>  |
| 3   | Рам               | 16       | 52       | <b>68</b>    | 25          | 32          | <b>57</b>    |
| 4   | Хөдөлгүүр засвар  | 94       | 160      | <b>254</b>   | 103         | 153         | <b>256</b>   |
| 5   | Кузов засвар      | 346      | 532      | <b>878</b>   | 442         | 500         | <b>942</b>   |
| 6   | Диск засвар       | 380      | 206      | <b>586</b>   | 255         | 238         | <b>493</b>   |
| 7   | Нум               | 244      | 156      | <b>400</b>   | 106         | 140         | <b>246</b>   |
| 8   | Накладка          | 1229     | 292      | <b>1521</b>  | 851         | 325         | <b>1176</b>  |
| 9   | Хурдны хайрцаг    | 32       | 204      | <b>236</b>   | 69          | 229         | <b>298</b>   |
| 10  | Хийн систем       | 1111     | 603      | <b>1714</b>  | 579         | 564         | <b>1143</b>  |
| 11  | Хөргөлтийн систем | 995      | 319      | <b>1314</b>  | 629         | 438         | <b>1367</b>  |
| 12  | Цахилгаан систем  | 1249     | 869      | <b>2118</b>  | 835         | 756         | <b>1591</b>  |
| 13  | Бусад             | 1647     | 909      | <b>2556</b>  | 803         | 810         | <b>1613</b>  |
|     | Нийт              | 7478     | 5396     | <b>12874</b> | <b>5575</b> | <b>5026</b> | <b>10601</b> |

Тээврийн хэрэгслийн гүйлт өндөр байгаагаас ашиглалтын үеийн техникийн эвдрэл гэмтэл гарч байгаа боловч гаралт багассантай холбоотойгоор өмнөх оны мөн үеийнхтэй засвар үйлчилгээний тоо хэмжээ багассан үзүүлэлттэй байна.

#### **Засвар үйлчилгээний тоо хэмжээний харьцуулсан график**



### Замд эвдэрсэн автобусны 2020 оны судалгаа

|   | Баазууд  | 2019 он | 2020 он | Өсөлт, бууралт |
|---|----------|---------|---------|----------------|
| 1 | 1-р Бааз | 31      | 28      | 3-аар буурсан  |
| 2 | 2-р Бааз | 77      | 54      | 23-аар буурсан |
|   | Нэгтгэл  | 108     | 82      | 26-аар буурсан |

1-р Бааз 2020 онд тээврийн хэрэгслийн шугам замд эвдэрсэн тохиолдол 28 гарсан нь 2019 оноос 3 тохиолдлоор буурсан дүнтэй байна. 2-р Бааз замд эвдэрсэн тээврийн хэрэгслийн тоо 54 гарсан нь өмнөх оноос 23-аар буурсан үзүүлэлттэй байна. Байгууллагын хэмжээнд замд эвдэрсэн тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос 26-аар буурсан байна. Нийт тээврийн хэрэгслийн дундаж гүйлт 680,000-850,000 км болсон байна.

### Баазуудын техник технологийн албаны ажлыг дүгнэх үзүүлэлт

| Баазууд  | Үзүүлэлт                  | 2020 он |         |         |         |         |         |         |         |         |          |          |                       | Эзлэх байр |   |
|----------|---------------------------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|----------|----------|-----------------------|------------|---|
|          |                           | 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар              | Нийт       |   |
| 1-р Бааз | ТББК                      | 92.5%   | 96%     | 95,20 % | 93,1%   | 93,9%   | 94,4%   | 94,4%   | 93,9%   | 90,9%   | 88.3%    | 91,4%    | 90%                   | 92,2%      | 3 |
|          | Техникийн сааталтай цаг   | 9.21    | 0       | 2,54    | 0       | 0       | 2.33    | 0       | 0       | 0       | 0        | 0        | 15.41                 | 30.2       |   |
|          | Замд эвдэрсэн т/х-ийн тоо | 6/2     | 4/1     | 3/3     | 7/2     | 10/3    | 5/0     | 18/0    | 13/3    | 6/0     | 20/5     | 4/1      | 6/0                   | 89/28      |   |
|          | Осол, зөрчил              | 0       | 0       | 0       | 0       | 0       | 0       | 0       | 0       | 0       | 0        | 0        | Амь нас алдсан 1 осол | 1          |   |
| 2-р Бааз | ТББК                      | 84.67   | 86.6    | 88.74   | 89,70   | 90,78   | 88,92   | 89,2%   | 89%     | 87,6%   | 84,37    | 85,03    | 87,3%                 | 87.46%     | 2 |

|        |                            |       |        |      |       |       |      |       |       |       |       |       |      |        |   |
|--------|----------------------------|-------|--------|------|-------|-------|------|-------|-------|-------|-------|-------|------|--------|---|
|        |                            | %     | %      | %    | %     | %     | %    |       |       |       | %     | %     |      |        |   |
|        | Техникийн сааталтай цаг    | 13.25 | 7.16   | 0    | 2,02  | 4,06  | 4,54 | 16,54 | 4,3   | 1,44  | 12,13 | 9,32  | 5,24 | 80.4   |   |
|        | Замд эвдэрсэн т/х-ийн тоо  | 167/4 | 121/12 | 42/3 | 2     | 10    | 0    | 87/1  | 54/2  | 42/0  | 8/9   | 1/3   | 7/0  | 529/54 |   |
|        | Осол, зөрчил               | 0     | 0      | 0    | 0     | 0     | 0    | 0     | 0     | 0     | 0     | 0     | 0    | 0      |   |
| ЦХАлба | ЦББК                       | 92%   | 87%    | 100% | 93,1% | 96,9% | 100% | 88,7% | 90,2% | 86,6% | 81%   | 83,7% | 86%  | 88,9%  | 1 |
|        | ЦХА-ны машин цагийн саатал | 0     | 8,5    | 0    | 0     | 0     | 0    | 0     | 0     | 0     | 0     | 0     | 8,4  | 16,9   |   |
|        | Кабелийн сүлжээний засвар  | 15    | 16     | 20   | 15    | 20    | 20   | 15    | 20    | 20    | 16    | 12    | 9    | 197    |   |
|        | Осол, зөрчил               | 0     | 0      | 0    | 0     | 0     | 0    | 0     | 0     | 0     | 0     | 0     | 0    | 0      |   |
|        |                            |       |        |      |       |       |      |       |       |       |       |       |      |        |   |

Энэ онд 2-р Баазын ТТА, ЦХА-д үйлдвэрлэлийн осол зөрчил гараагүй, 1-р Баазын засварчин А.Цэндноров 2-р гаражийн хойд талбайд 1-041 автобусны жолооч Ганхуягийн гуйлтаар хийг нь гэсгээж байхад жолооч Өлзийбал автобусыг хөдөлгөж амь насыг нь хохироосон харамсалтай осол гарсан. 1-р Баазын ТББК 92,2 хувь, 2-р баазын ТББК 87,46 хувьтай байна. 2-р Бааз ТББК-ийг 90 хувьд хүргэх зорилтоо биелүүлж чадаагүй ба энэ нь ажлын багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангалт муу, засвартай удаан хугацаагаар зогсч байгаа тээврийн хэрэгсэлд сэлбэг материал хангалтгүй нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

#### Техникийн комиссын актны судалгаа 469/1483

| Д/д | Актны төрөл        | Баазууд  | Актны тоо | Тоо | Шалтгаан        | Дүн                                   |
|-----|--------------------|----------|-----------|-----|-----------------|---------------------------------------|
| 1   | Дугуй 233/852      | 1-р Бааз | 123       | 448 | норм дууссан    | шагнал-9,007,579₮<br>төлбөр-749,870₮  |
|     |                    | 2-р Бааз | 110       | 404 | норм дууссан    | шагнал-4,228,360₮<br>төлбөр-387,800₮  |
| 2   | Аккумулятор 82/157 | 1-р Бааз | 43        | 86  | хугацаа дууссан |                                       |
|     |                    | 2-р Бааз | 39        | 71  | хугацаа дууссан | төлбөр-1,050,600₮                     |
| 3   | Хохирол 154/474    | 1-р Бааз | 85        | 405 | кузов аваар     | төлбөр-18,030,100₮                    |
|     |                    | 2-р Бааз | 69        | 69  | кузов аваар     | төлбөр-10,730,600₮<br>шил-13,221,247₮ |


2020 онд нийт 469 нэр төрлийн 1483 ш акт бичсэн ба шагнал 13,235,939₮, төлбөр 44,170,217₮ бичиж өмнөх оноос илүү гүйлтийн шагнал 3,418,794₮-өөр бага, төлбөр 13,763,410₮-өөр бага байна.

#### ЦХА-ны 10 жилийн саатлын харьцуулалт

| Он<br>Сар      | 2010<br>он | 2011<br>он | 2012<br>он | 2013<br>он | 2014<br>он | 2015<br>он | 2016<br>он | 2017<br>он | 2018<br>он | 2019<br>он | 2020<br>он |
|----------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| 1-р сар        | 72         | 0          | 17         | 0          | 6          | 51         | 44         | 30         | 5          | 2          | 0          |
| 2-р сар        | 0          | 72         | 78         | 29         | 13         | 46         | 12         | 2          | 8          | 10         | 8:50       |
| 3-р сар        | 0          | 18         | 42         | 13         | 12         | 20         | 26         | 9          | 0          | 9          | 0          |
| 4-р сар        | 30         | 31         | 133        | 43         | 15         | 51         | 45         | 18         | 0          | 0          | 0          |
| 5-р сар        | 142        | 5          | 108        | 80         | 0          | 65         | 16         | 21         | 6          | 16         | 0          |
| 6-р сар        | 105        | 50         | 33         | 50         | 0          | 45         | 18         | 42         | 0          | 0          | 0          |
| 7-р сар        | 9          | 85         | 187        | 64         | 60         | 46         | 31         | 0          | 0          | 12         | 0          |
| 8-р сар        | 75         | 31         | 28         | 110        | 81         | 21         | 20         | 26         | 13         | 0          | 0          |
| 9-р сар        | 70         | 15         | 86         | 176        | 149        | 22         | 40         | 12         | 14         | 0          | 0          |
| 10-р сар       | 260        | 0          | 33         | 256        | 34         | 129        | 44         | 9          | 0          | 9          | 0          |
| 11-р сар       | 75         | 85         | 69         | 136        | 0          | 31         | 26         | 6          | 0          | 10         | 0          |
| 12-р сар       | 70         | 73         | 81         | 48         | 41         | 11         | 9          | 22         | 8          | 0          | 8:40       |
| Бүгд<br>саатал | 908        | 469        | 895        | 1005       | 410        | 538        | 331        | 197        | 54         | 68         | 17:30      |

Цахилгаан хангамжийн албаны хэмжээнд цахилгааны саатал 2019 онд 68 цаг гарч байсан бол 2020 онд 17:30 цаг гарч 3,8 дахин буурсан үзүүлэлттэй байна.

### ЦХА-ны саатлын 2020 оны харьцуулалтын график



### Эрчим хүчний нэгдсэн мэдээ 2020 он

| №      | 2019 он |         |        |        |             | 2020 он |         |        |        |              |
|--------|---------|---------|--------|--------|-------------|---------|---------|--------|--------|--------------|
|        | Бүгд    | Шугам   | депо   | Д/Х    | саатал      | Бүгд    | Шугам   | депо   | Д/Х    | саатал       |
| 1 сар  | 529820  | 387586  | 104400 | 37834  | <b>2:10</b> | 528318  | 392293  | 97400  | 38625  | <b>0</b>     |
| 2 сар  | 493700  | 360148  | 96200  | 37352  | <b>10</b>   | 486960  | 354497  | 95200  | 37263  | <b>8:50</b>  |
| 3 сар  | 340980  | 257436  | 57000  | 26544  | <b>9</b>    | 285160  | 175891  | 78800  | 30469  | <b>0</b>     |
| 4 сар  | 325096  | 250829  | 52600  | 21667  | <b>0</b>    | 264060  | 187785  | 53600  | 22675  | <b>0</b>     |
| 5 сар  | 275480  | 215872  | 42800  | 16808  | <b>16</b>   | 231660  | 171087  | 46200  | 14373  | <b>0</b>     |
| 6 сар  | 214420  | 170876  | 32800  | 10744  | <b>0</b>    | 234880  | 181344  | 42800  | 10736  | <b>0</b>     |
| 7 сар  | 195125  | 155014  | 32200  | 7911   | <b>12</b>   | 199610  | 154953  | 36800  | 7857   | <b>0</b>     |
| 8 сар  | 207580  | 163861  | 35000  | 8719   | <b>0</b>    | 207540  | 162694  | 37200  | 7646   | <b>0</b>     |
| 9 сар  | 223311  | 175527  | 36800  | 10984  | <b>0</b>    | 227820  | 175077  | 41800  | 10943  | <b>0</b>     |
| 10 сар | 262600  | 205463  | 41400  | 15737  | <b>9</b>    | 271020  | 202148  | 50800  | 18072  | <b>0</b>     |
| 11 сар | 368220  | 279562  | 65200  | 23458  | <b>10</b>   | 272460  | 194534  | 55400  | 22526  | <b>0</b>     |
| 12 сар | 462300  | 333761  | 94600  | 33939  | <b>0</b>    | 398060  | 277205  | 88200  | 32655  | <b>8:40</b>  |
| Нийт   | 3898632 | 2955935 | 691000 | 251697 | <b>68</b>   | 3642328 | 2659894 | 723800 | 258634 | <b>17:30</b> |

“Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээ”-тэй ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2020÷2021 оны Өвөлжилтийн бэлтгэл хангасан байдлыг шалгах НТҮГ-ын даргын 2020 оны 09 сарын 25-ны өдрийн А/70 тоот тушаал гарч “Өвөлжилтийн бэлтгэл ажлын хангуулах ажлын хэсгийн удирдамж”-ийн дагуу ажлын хэсгийн шалгалт Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т 2020 оны 09 дүгээр сарын 30 нд ирж өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгалаа.

**НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИЙН 2020-2021 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ШАЛГАХ ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

| Д/Д                     | Үзүүлэлтүүд                                                                                                                                                                                                                      | Авбал<br>зохи<br>оноо | ЗТН  |
|-------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|------|
| Байгууллагын нэр        |                                                                                                                                                                                                                                  |                       |      |
| Шалгасан өдөр           |                                                                                                                                                                                                                                  |                       |      |
| Үйлчилгээний чиглэл     |                                                                                                                                                                                                                                  |                       |      |
| Тээврийн хэрэгслийн тоо | Дансны тээврийн хэрэгсэл                                                                                                                                                                                                         | 279                   | 279  |
|                         | Үзлэгт орсон тээврийн хэрэгсэл                                                                                                                                                                                                   | -                     | -    |
| 1                       | Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт                                                                                                                                                  | 5                     | 5    |
| 2                       | Автобусны дулаан зогсоолын хэмжээ, стандартын дагуу байгаа эсэх                                                                                                                                                                  | Өөрийн 5              | 5    |
|                         |                                                                                                                                                                                                                                  | Түрээсийн 2           |      |
| 3                       | Автобусыг зогсоолд байрлуулах схем, дарааллыг зөв байрлуулсан эсэх                                                                                                                                                               | 2                     | 2    |
| 4                       | Засвар, үйлчилгээний байр болон конторын барилгын засвар, дулаалга, агааржуулалт, засварын байр, гаражийн гэрэлтүүлэг бүрэн хангагдсан эсэх                                                                                      | 5                     | 4    |
| 5                       | Хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдлын хангалт. Гал унтраах багаж хэрэгсэлийн бүрдэлт, хадгалалт хамгаалалтын байдал                                                                                                          | 10                    | 10   |
| 6                       | Хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, эмчийн үзлэг, ХАБ-ын зааварчилгаа өгсөн байдал                                                                                                                                 | 6                     | 5,25 |
| 7                       | Халаалтын системийн найдвартай ажиллагаа, дүгнэлт. /МУ-ын ЗГ-ын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилт/                                                                                                                          | 3                     | 3    |
| 8                       | Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний нэгдсэн график, төлөвлөгөө гарган, биелэлтийг ханган ажиллаж байгаа эсэх /удаан засвартай зогссон, хөдөлгүүр сольсон тээврийн хэрэгслийн тоог авах/                                      | 7                     | 7    |
| 9                       | Засварын байрны тоног, төхөөрөмжийн хангалт, төрөл нь засвар үйлчилгээний технологийн картанд заагдсан багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх                                                                                    | 5                     | 4    |
| 10                      | Шалгах хуудсыг өдөр тутам хэрэгжүүлж хэвшүүлсэн байдал, цонхны цанталтыг бууруулах шилийг бүрэн наасан байх, УБ смартын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах, ариутгал халдваргүйжүүлэлтийг графикийн дагуу хийсэн байдал | 10                    | 5,5  |
| 11                      | MNS 4302:2011 стандартын 8.4 дэх нөхцөл шаардлагын дагуу автобус бүрийн заалны дулаацуулга хөргөлтийн системд график төлөвлөгөө гарган цэвэрлэж улирлын                                                                          | 6                     | 3    |

|                    |                                                                                                                                                                                                                 |            |              |
|--------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------|
|                    | үйлчилгээг бүрэн хийж, найдвартай ажиллагааг хангасан байх                                                                                                                                                      |            |              |
| 12                 | Боловсон хүчний хангалт /мэргэжлийн ИТА-тай эсэх/                                                                                                                                                               | 5          | <b>5</b>     |
| 13                 | Автобусны хүрэлцээ, парк шинэчлэлт, нөхөн хангалт хийсэн байдал                                                                                                                                                 | 10         | <b>10</b>    |
| 14                 | Зайлшгүй шаардлагатай сэлбэг, шатах тослох материал, хөлддөггүй шингэний нөөцлөлтийн хэмжээ, төрөл, үнийн дүн, аккумуляторын нөөцлөлт, найдвартай ажиллагааг шалгах, цонхны цанталтыг бууруулах шилний нөөцлөлт | 10         | <b>10</b>    |
| 15                 | Шатахуун импортлогч компаниудтай гэрээ хийсэн болон тухайн байгууллагын хэрэгцээний ШТС, суурин болон зөөврийн станц нь мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл авсан эсэх                                            | 3          | <b>3</b>     |
| 16                 | Замд техникийн саатлаар зогссон автобусыг чирэх чирэгч автомашин болон техникийн түргэн тусламжийн машины бэлэн байдлыг хангаж, хуваарйн дагуу ажиллуулсан эсэх                                                 | 3          | <b>2,7</b>   |
| 17                 | Жолоочийг өвлийн ажлын хувцсаар хангасан байдал, суудлын бүрээсийн хангалт /нөөц, шугам замд шалгах/                                                                                                            | 5          | <b>5</b>     |
| <b>НЭГДСЭН ДҮН</b> |                                                                                                                                                                                                                 | <b>100</b> | <b>89,45</b> |

Тайлант хугацаанд НТҮГ-т өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 24 нд биелэлт 84,5 хувьтай, 2020 оны 08 дугаар сарын 24 нд биелэлт 88,3 хувьтай, 2020 оны 09 дүгээр сарын 24 нд 90,9 хувьтайгаар 3 удаа хугацаанд нь хүргүүлсэн ба хийсэн ажлуудыг дүгнэвэл:

1-р Баазын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 25 ажил хийхээр төлөвлөж батлуулснаас гүйцэтгэл 82.6 хувьтай байна.

2-р Бааз 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 44 ажил хийхээр төлөвлөж гүйцэтгэл 95.2 хувьтай байна.

ЦХА 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө, график гарган ажилласан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 9 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд графикийн дагуу техникийн үйлчилгээ, засварын ажлыг гүйцэтгэж байна. Төлөвлөгөөний биелэлт 94 хувьтай байна.

Байгууллагын нийт дүнгээр 80 ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний биелэлт 90.9 хувьтай гүйцэтгэсэн талаар 2020 оны 09 дүгээр сарын 24 нд НТҮГ-т биелэлт хүргүүлсэн. НТҮГ-ын ажлын хэсгийнхэн өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах үнэлгээний үзүүлэлтүүд гэсэн 17 үзүүлэлтээр шалгаж нийлбэр дүнгээр 89,45 оноогоор хангалттай үзүүлэлтээр ажлаа дүгнүүлсэн.

2019 онд өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах ажлын хэсэг ирж өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгахад байгууллагын хэмжээнд 81.4 хувиар ажлаа дүгнүүлж байсан бол 2020 онд байгууллагын хэмжээнд 89.45 оноо авч урд оныхоос 8.05 хувиар ажил дээшилсэн үзүүлэлттэй байна.

ТХ-ийн хэмжээнд 2020 оны байдлаар төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийг авч үзвэл:

1-р Бааз нийт 64 ажил төлөвлөсөн. хөрөнгө шийдэгдээгүй 4 ажил, 100 хувь биелэлттэй 52 ажил, 93 хувийн биелэлттэй 1 ажил, 90 хувийн биелэлттэй 1 ажил, 70 хувийн биелэлттэй 4 ажил, 10 хувийн биелэлттэй 2 байна. Нийт ажлын биелэлт 94,7 хувьтай байна.

2-р Бааз нийт 31 ажил төлөвлөсөн. 100 хувийн биелэлттэй 27 ажил, 97,6 хувийн биелэлттэй 1 ажил, 90 хувийн биелэлттэй ажил, 75 хувь биелэлттэй 1 ажил, 50 хувь биелэлттэй 1 ажил байна. Нийт ажлын биелэлт 97,1 хувь байна.

ЦХА нийт 21 ажил төлөвлөсөн. Үүнээс 100 хувь биелэлттэй 15-н ажил, 75 хувийн биелэлттэй 3 ажил, 50 хувийн биелэлттэй 1 ажил, гүйцэтгээгүй 1 ажил байна. Нийт биелэлт 84,5 хувьтай байна.

Техникийн хэлтсийн хэмжээнд /хэлтсийн ХАБЭААлба, Ерөнхий механикийн албанд давхцсан тоогоор 26 ажил төлөвлөж 100 хувийн биелэлттэй 19 ажил, 90 хувийн биелэлттэй 1 ажил, 80 хувийн биелэлттэй 1 ажил, 60 хувийн биелэлттэй 1 ажил, 50 хувийн биелэлттэй 1 ажил, 0 хувийн биелэлттэй 3 ажил, нийт 4-н төрлийн 125 ажил төлөвлөж ажлын биелэлт 90,02 хувь гүйцэтгэлтэй байна.

НТҮГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/21 тоот тушаалаар Нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд, бага багтаамжийн автобус, троллейбус, ажилчдын автобус, таксийн тээврийн хэрэгслийн хаврын ээлжит Техникийн хяналтын үзлэгийг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд явуулахаар болсон. Үүний дагуу тус байгууллагын 1, 2 дугаар баазын ИТА, засварчид тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангах, кузов засвар, өнгө будгийг сэргээх ажлыг стандартын хэмжээнд хийж гүйцэтгэсэн.


Тээврийн хэрэгслийн хаврын үзлэг, оношилгоонд нийт орох ёстой 280/276 тээврийн хэрэгслээс 1-р Бааз 2020 оны 05 дүгээр сарын 21-нд нийт 149 тээврийн хэрэгсэл, 2-р Бааз 2020 оны 05 дугаар сарын 14 нд 127, нийт 276 тээврийн хэрэгсэл үзлэг оношилгоонд оруулж тэнцүүлэн тээврийн хэрэгслийн хаврын ээлжит Техникийн хяналтын үзлэгийг графикт хугацаанаас өмнө нь дуусгасан амжилттай ажилласан.

1-р Бааз намрын техникийн хяналтын оношлогоонд бэлтгэж 149 автобусны кузов засварыг бүрэн хийж дууссан. 2020 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар нийт 121 автобус оношлогоонд орж 81,2 хувьтай хамрагдаж тэнцээд байна. 2-р Бааз нийт 125 тээврийн хэрэгслээс 98 тээврийн хэрэгсэл үзлэг оношилгоонд тэнцэж байгууллагын хэмжээнд 219 тээврийн хэрэгсэл 79,6 хувьтай үзлэг оношилгоонд тэнцсэн байдалтай байна. Ковид 19 вируст тархалтын улмаас хөл хорио тогтоосноос шалтгаалан оношлогооны төвийн үйл ажиллагаа зогсож үзлэгийн графикт хугацаа хойшилсон.

### 3.2. Барилга байгууламжийн засвар үйлчилгээний ажлын хүрээнд:

1-р баазын ЗҮС-ын I, II, III, V сувгуудын гэрлүүдийг засварлаж шатсан 12 гэрлийг 40 Вт лед гэрлүүдээр сольж засварлаж гэрлийг гүйцээж хийсэн. Кузов цехийн урд болон хойд талын талбайн нийт 8 гэрлийн 11 м кабелийг троссоор давхар бэхэлгээ хийж татаж мэдрэгч цагийн релег шинээр сольж тавьж асааж тохируулан бэлэн болгов.

2-р конторын халуун усны өрөөний агааржуулалтын хоолой цантаж бөглөрсөн байсныг агаарын хоолойг салган авч дотор мөс цанг арилгаж тавьсан.




Халуун усны өрөөний агааржуулалтын хоолойг засварлаж байгаа байдал

Туршилтаар ирсэн цахилгаан автобусны цэнэглэгчийн байр бэлтгэх ажил хийгдэж, дотор талыг цементэн хавтангаар доторлож, гадна талыг төмөрлөж, дээврийн хэсэгт рам хийж төмөрлөж бэлэн болгосон. Цахилгаан автобусны цэнэглэгч



суурилуулахтай холбогдуулан ЗҮС-ын цахилгааныг тэжээгч трансформаторыг чөлөөлөн цахилгаан автобусны цэнэглэгчийг холбож ЗҮС, 2-р конторын цахилгааныг ХТП 244-рүү шилжүүлэн холбох ажил хийгдсэн. ХТП 244-өөс цахилгаан тэжээл авч байсан угаалга, 1, 2-р гаражийн цахилгааныг шилжүүлэн ХТП 656-д холбосон. ХТП 244, 656-н автоматууд ашиглалтын явцалд муудаж бохирдсоны улмаас тог таслахад нэг фаз салахгүй масс үүссэн тул шинээр Шоо-70 рубильник, 250А-тай автомат авч сольж тавьсан. Автобус цэнэглэгчийн зогсоолд хязгаарлагч боож, чиглүүлэгч зурвасыг цагаан будгаар будаж аюулгүй байдлыг хангасан.

Цахилгаан автобусны цэнэглэгч суурилуулахтай холбогдуулан ЗҮС-ын цахилгааныг тэжээгч трансформаторыг чөлөөлөн цахилгаан автобусны цэнэглэгчийг холбож ЗҮС, ЗТН-ийн цахилгааныг ХТП 244-рүү шилжүүлэн холбосон 200 м кабель



утас булж далдлах ажил хийгдэж дууссан.

2020 оны 04 дүгээр сарын 06-нд мэргэжлийн байгууллагаар 1-р баазын үүдний хөнгөн цагаан хаалгыг авч шинээр металл хаалга суурилуулсан.




Цахилгаан автобусны цэнэглэх байр болон төхөөрөмж



ЗТН-ийн урд 10 ш, ЗҮС-ын урд 10 ш, зүүн талд 7 ш, Колонкийн урд ба ард 23 ш, УТБ-ны гадна 7 ш, Сургалтын төвийн урд 10 ш, Күзов цехийн урд 10 ш. Нийт 87 ш цэцгийн савнуудыг будгийг арилгаж шинээр будаж байрлуулж 800 ш цэцэг суулгалаа.

Автобус угаалгын төхөөрөмжийн хаягдал усыг дахин цэвэршүүлэх зориулалттай төхөөрөмжийн өндөр даралтын олон шатлалт хос насосон дээр байдаг хог шүүгч бохирдсон байсныг цэвэрлэж, цахилгааны монтажийг шинээр хийж ашиглахад бэлэн болгосон. Автобус угаалгын тэжээлийн цахилгаан доголдож угаалга ажиллахгүй болсон тул шалгаж гэмтэлтэй байсан пускателийг сольж ажилд оруулав.

Автобус угаалгын төхөөрөмжийн усны шугаман дээр тавигдсан автомат хаалт гацаж усаа дутуу шахаж байсан тул цахилгаан хаалтыг авч Ф25-тай энгийн хаалтаар сольж, саарал усны шахалтыг буцах шугаман дээр нь тавьж хэвийн ажиллагаатай болгов.



Автобус угаалгын төхөөрөмжийг угсарсан байдал


2-р конторын араар явсан бохирын худаг бөглөрч, 3-н худаг дүүрч гадагш бохир алдах болсныг гадны байгууллагаас бохир соруулж буудах төхөөрөмжтэй машин дуудаж 3-н удаа соруулж, буудуулан бөглөөсийг гаргасан. Баазын хашааны зүүн талын хаалгыг баруун хаалган дээр аваачиж тавьж моторыг авч контейнерт хийсэн. 2-р конторын 1 давхарт байгаа угаалгын машины моторын холхивчийг сольж бохирын хоолойн хог шороог авч цэвэрлэв. I, II, III, IV, V /дугуйн/ сувгийн домкратны хийн тунадас авах, шингэн нэмэх, сальник солих, хийн клапанд үйлчилгээ хийж тасралтгүй ажиллагааг хангах ажлууд хийгдсэн. ЗҮС-ын дугуйн компрессорт техник үйлчилгээ хийж масло тосыг шинээр сольж, цэвэрлэгээ хийж цахилгааны утас болон пускателийн бүтэн байдалд үзлэг хийж үйлчилгээ хийсэн.





Засвар үйлчилгээ хийсэн байдал

НЗД-ын 2020 оны А/85 тоот захирамжаар батлагдсан нийслэлийн төсвөөс эрх шилжин ирсэн НХААГ/202001244 дугаартай “Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын баазын гаражуудын их засвар, агааржуулалтын ажил” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнийн санал авах тендерт 1,498,991,405 төгрөгийн үнэ санал болгон шаардлагад нийцсэн Ди Вай Кэй Би ХХК-тай 2020 оны 08 сарын 19-нөөс гэрээ байгуулан 2020 оны 10 сарын 19 нд гүйцэтгэлийг хүлээн авахаар төлөвлөсөн байсан.

1-р гараж засвар хийхийн өмнө



### Засвар хийж буй байдал



1-р бааз барилгын засвар ажлын явц хянах ажлын хэсэг гарган ажилласан.

Энэ хугацаанд 2020 оны 10 сарын 21 нд байгууллагын удирдлагууд бүрэн бүрэлдэхүүнээр барилгын менежер Цэвээнхүүтэй барилгын ажлыг шуурхайлах талаар протоколтой хуралдав. Хурлаар эхний ээлжинд 7-н зүйлийг яаралтай хийж гүйцэтгэх талаар тохиролцов. Үүнд:

1. Хаалга ямарыг солихыг шууд шийдэх.
2. Хаалганы гадна доод налууг яаж гаргах талаар шийдэл
3. Бетон дээр резинэн будгийг энэ жил зайлшгүй хийж байж автобус оруулж байршуулах ёстой.
4. Өнгө тохирох /өмнө нь зураг гаргах ёстой байсан/
5. Парны хамгаалалтын шийдэл
6. Аюулгүй ажиллагааг барилгын компани хангаж ажиллах
7. Цонхнууд солих гэх зэрэг болно.

Энэ хугацаанд Ди Вай Ки Би ХХК-д 2020 оны 10 сарын 26 нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан “Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1, 2 баазын гаражуудын их засвар, агааржуулалтын ажил” гүйцэтгэх гэрээний хугацаа 2020 оны 10 дугаар сарын 20 нд дууссан. Дээрх хугацаанд засварын ажлыг дуусч ашиглалтад оруулан хүлээлгэж өгнө гэж заасан боловч 2020 оны 10 дугаар сарын 26-ны байдлаар засвар хийж буй эхний объектын засвар дуусаагүй байдалтай байна. Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан гадаа байрлуулж байгаа автобус өглөө асахгүй, тоормосны систем хөлдөж тоормоз барихгүй зэрэг хүндрэлүүд гарч НТҮГ-тай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний үүргээ биелүүлж чадахгүйд хүрсэн тул засварын ажлыг яаравчлах талаар албан бичиг өгсөн.

Байгууллагын захирлын зөвлөл 2020 оны 10 дугаар сарын 21 нд Ди Вай Кэй Би ХХК-ний менежер Цэвээнхүүг байлцуулан хуралдаж 1-р гаражийн засварын ажлаас 7-н зүйлийг засварлаж дуусгах боломжтой талаар нэгдсэн шийдвэрт хүрсэн. Иймд эхний объектын засварыг дууссаны дараа дараагийн ажлууд эхлэх хугацааг тохиролцох шаардлагатай гэж үзэж байна гэсэн утгатай албан бичгийг өгсөн. Хөрөнгө оруулалт, хангамжийн албаны худалдан авалт хариуцсан мэргэжилтэн Б.Даваасүрэнгээр НӨАУГ, НХОГ руу мэргэжилтэн томилуулж ажлын хэсгээр явцын хяналт хийлгүүлэх тухай албан бичгийг гаргуулж 2020 оны 11 сарын 05 нд хүргүүлсэн.

2020 оны 11 дүгээр сарын 07-ноос 09-ний хооронд 1-р гаражийн шалыг эпоксид будгаар будаж 7 хоног хатаасны дараа 11 дүгээр сарын 15-наас эхлэн автобусуудыг зогсоолын тэмдгийн дагуу байрлуулж эхэлсэн. Бусад ажлын хувьд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор түр засварласан байдалтай байна.

Засвар үйлчилгээний станцын урд борооны ус зайлуулах сувгийн решотик цөмөрч орсон тул засварчин Нямсамбуу, Б.Батсүх нараар төмөр тавьж гагнуулж



засварласан.

I, II, III, IV, V /дугуйн/ сувгийн домкратны хийн тунадас авах, шингэн нэмэх, сальник солих, хийн клапанд үйлчилгээ хийж тасралтгүй ажиллагааг хангах ажлууд хийгдсэн.



Засвар үйлчилгээний станцын үзельд Ф125-ын хаалт 2 ширхэг буцаахгүй клапан 2 ширхэгийг сольж засвар үйлчилгээ хийж цэврэлгээ хийгдлээ.



1-р гаражийн урд хогийн цэгийн хажууд цэвэр усны шугам цоорч ус алдсан байсныг өөрсдийн хүчээр ухаж гагнаж булав.



1-р гаражийн цахилгааны хуучин шитнүүдийг шинээр угсар сольж тавьсан

Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар.



Бохирын худгийн бөглөөс гаргасан ба угаалгын хаалга зассан байдал


2-р Бааз хуваарийн дагуу тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж байна. Үүнд: В корпусын цахилгаан автобус байрлах өрөөнд нэмэлт гэрэл хийсэн. Угаалгын машины бохир ус юлэх хаалт эвдэрч катушка хийж засварласан. 3-р сувгийн 8-р домкратад 1.5 кВт-ын мотор ороолгож тавьж зөөлөн холбоо солив. Сувгийн гэрэлтүүлэгт засвар хийж 8 ш гэрэл солив. Сувгийн жижиг компрессорын залгуур солив. Е коркуст 2 ш унтраалга сольж тавив. Складанд 2 ш гэрэл солив. 2-р сувгийн домкратуудын тэжээлийн утас болон пускатель сольж засварлав. Мотор цех болон конторын ОО-д шинээр 3 ш гэрэл хийв. Мөн 1-р сувгийн 3-р домкрат, 3-р сувгийн 7-р домкратын гуулин втулка эвдэрч зогссон тул шаардлагатай сэлбэгийг захиалганд өгсөн. Конторын 2 давхрын ОО-ын өрөөний монтажийг шинээр хийж гэрэл солив. В корпусын винткамер 2-ын мотор шатаж сольж засварлав. Дугуй цехийн компрессорт үйлчилгээ хийж хий алдалт засварлав. Татах дэд станц 7-ийн дотуур холбооны утас гэмтсэнийг засварласан. Засварын депогийн 4-р сувгийн 3-р домкратын автомат шатсаныг сольсон. Засварын 2-р сувгийн гэрлийн монтажийг шинээр засварлаж татах автомат солив. Том узелийн гэрэл шатаж 4 ш гэрэл сольж тавив. 2-р сувгийн тележканы кабелийн тросс тасарсныг засварлав. Урд талбайн гэрэлтүүлгийн автомат солив. Автобус угаалгын төхөөрөмжинд үзлэг хийж тосолгоо хийсэн. Вентикамер 3-ийн удирдлагын гар эвдэрснийг засварласан.

Инженерийн байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар.

2-р Бааз Винткамеруудыг графикийн дагуу 2 цаг тутамд асааж, унтрааж байна. Дугуйн цех дотор галын гидрантын ф50-ийн труба цоорсныг засав. Мөн агуулахын тосны өрөөнд ф25-ийн дулааны хоолойгоор ус алдаж PVC хоолойг сольж засварлав. Засварын сувгийн завесийн ус шүүрч байгаа хэсгийг засварлаж ТДС 10 дээр 2 давхрын таазнаас ус гоожиж байна гэсэн дуудлагаар очиж бойлерын хүйтэн усны шугамаар гоожиж байгааг тогтоож усыг түр хаах арга хэмжээ авсан. Шинэ угаалгын хүйтэн усны шугаманд ф25-ийн крант гагнаж ус өгөв. Депогийн ОО-д ф15-ийн дундын хаалт, хөвүүр тавив. Цэцэрлэгт ОО-ийн уян хоолой 2 ш сольсон. Конторын ОО нийт 2 удаа бөглөрснийг тросс гүйлгэж гаргав. Төв угаалгын машины шланг цоорсныг засварлав. Угаалганд 10 ш ф15-ийн хаалт сольж засварласан. Засварчдын хувцас солих өрөөний угаалтуураас хүйтэн ус гоожиж байгааг зассан.

Төвийн дулааны шугамын Ф219-ийн шугамыг солих ажлыг сантехникчдийн хүчээр хийж гүйцэтгэсэн.





Энэ оны 1-р сард Нийтийн тээврийн үйлчилгээний стандартын дагуу ашиглалтын хугацаа дууссан 2-003 дугаартай троллейбусыг хөшөөт цогцолбор болгон байрлуулж тохиуилтын ажлыг хийж байна. Байгууллагын үүдний садны хоёр талын хаалга болон хайсыг сольсон. Аж ахуйн хашааг цэвэрлэж ар талаар нь хайс хийж битүүлэн айл буулгаж эзэнжүүлсэн. Засварын Депогийн баруун талын зүлгийг гишгүүлж зүлэгжүүлэн цэцэг тарьсан. Шалгах механикийн байрны урд талд байсан бетон хавтангуудыг эмхлэн хурааж барилгын урд талын хаалгыг хайсаар хааж битүүлсэн.



2-003 троллейбусыг хүндэтгэлийн тавцанд суурилуулсан байдал

3.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль дүрмийн хүрээнд зохион байгуулсан ажлын талаар:


Тайлант хугацаанд шинээр ажилд орсон ажилтанд өгөх анхан шатны урьдчилсан зааварчилгааг 124 ажилтанд, давхардсан тоогоор 62,614 ажилтанд давтан зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

Хэсгийн дарга, Засварын инженер, Ерөнхий механикийн инженер ЦХА-ны инженерүүдийн ажилчиддаа өгч байгаа давтан зааварчилгаа болон өдөр тутмын зааварчилгааны бүртгэлийн 35 дэвтрийг долоо хоног бүр буюу нийт 60 удаа шалган гарын үсэг зурж баталгаажуулсан.

Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах зорилгоор объектууд, хөдлөх бүрэлдэхүүний гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг 22 удаа үзлэг, шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулсан. Тээврийн хэрэгслүүдэд шалгалт хийхэд нийт 285 хөдлөх бүрэлдэхүүний 570 ш галын хор шалгагдахаас галын хор дутуу 23 автобус, хошуу эвдэрсэн 42 ш, цэнэггүй болсон 100 ш, нийт 165 зөрчил илэрснийг арилгуулж, галын хор болон эмийн сангийн нөхөн хангалтыг хийж аюулгүй байдлыг ханган ажилласан.

Засвар үйлчилгээний багаж, тоног төхөөрөмжийн найдвартай аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт тогтмол хийж шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар өглөөний шуурхайд мэдээлэл хийж, холбогдох албан тушаалтанд зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч ажилласан.

ТТА-ны ахлах инженерийн баталсан тоног төхөөрөмжинд хийгдэх техникийн үзлэг үйлчилгээний графикийн дагуу үзлэг үйлчилгээ хийгдэж буй эсэх, токарийн суурь машин, наклад хадагч суурь машин, дугуй задлагч, точиль, суурин өрөмний найдвартай аюулгүй ажиллагаанд сар бүр тогтмол үзлэг шалгалт хийж засварын станцын гар ажиллагаатай домкрат ажиллахгүй байгаа зөрчил гарсныг шалгаад цаашид ажиллуулах боломжгүй талаар шаардлага бичиж техник технологийн хэлтэст хүргүүлсэн ба багаж тоног төхөөрөмжийг засварлуулан хэвийн ажиллагааг хангуулж ажиллалаа.



1, 2-р гаражийн галын дотуур крантуудыг бүрэн ажиллагаатай болгосон

2-р баазын цахилгаан тоног төхөөрөмжинд хариуцсан инженер, механикууд хариуцан тухайн тоног төхөөрөмжийн засварчин өдөр тутамдаа засвар үйлчилгээ, тосолгоо хийсэн.

Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ, галын хорны нэгдсэн бүртгэлийн дагуу сар бүр шалган баталгаажуулж байна, МАЗ автобусны галын хорны хугацаа норм дууссан, галын хорны лац эвдэрч цэнэггүй болсон BFZ-4 маркийн галын хорыг сольж байршуулсан.


ЦХА-ны Кабелийн бригадаар байгууллагын нийт барилга байгууламж, тоног төхөөрөмж, цахилгаан байгууламжийн болон цахилгааны шитны газардуулгын хэмжилт туршилт, шалгалтыг Кабелийн инженер Ч. Ашим, засварчин Энхбат нар хийсэн. Хэмжилт хийхэд илэрсэн зөрчил болох шинээр сольж хийсэн цахилгааны шитний газардуулга хийгээгүй байсныг илрүүлж Ерөнхий механикт үүрэг өгч зөрчлийг хэвийн болгож ажиллаа.

Контактын сүлжээний тусгай автомашины бэлэн байдал, бригадын засварчдын хамгаалах хэрэгсэл, ажлын багаж түлхүүрэнд үзлэг шалгалт хийсэн. Үзлэг шалгалтыг КС-ний инженер Б.Баатарцогттой хамт хийж тусгай дуут дохиот тээврийн хэрэгслийн галын хорыг 2 ш болгож нэмэгдүүлсэн. Тусгай хамгаалах хэрэгсэл дутмаг, хугацаа норм дууссан шаардлага хангахгүй болсон байдалтай байна. Хүндрүүлэгтэй тюмблер захиалганд өгсөн боловч ирээгүй байна.

Сургалтын төлөвлөгөөний дагуу Нарны зам сургалтын төвтэй хамтарч засварчдад багаж тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааг хангуулах талаар “Нарны зам” сургалтын төвтэй хамтран 1 цагийн сургалт явуулсан.



Троллейбусны жолооч нарт тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны сургалтыг явуулж санал хүсэлтийг нь сонсож харилцан ярилцаж, цаашид анхаарах асуудлыг хэлэлцсэн.



2020 оны 1-р сард троллейбус, автобусны нийт жолооч нарыг 2 ээлжээр цуглуулж ХАБЭА-н талаар сургалтыг явуулж угсраа автобусны жолооч нараас тестийн шалгалт авч хангалтгүй дүн үзүүлсэн жолооч нарыг Нарны зам сургалтын төвд давтан сургалтанд хамруулсан. Мөн ИТА-дад ХАБЭА-н талаар сургалт видео шторк бэлдэж сургалт явуулж үүдний хэсэг болон ээлжийн инженерийн үүдэнд дэлгэцээр үзүүлж байна. Депогийн засварчидад ХАБЭА-н сургалт орж ажлын байрны АА-ны талаар цогц сургалт хийсэн. Давхардсан тоогоор нийт 135 засварчид хамрагдсан.

2020 оны 12 сарын 14-ний өдөр 1, 2-р Баазын засварчдад “Цахилгаан гар багаж болон бага оврын тоног төхөөрөмж аюулгүй ажиллагаа”, “Ажлын байрны нэгээс нөгөөд шилжих, шинэ тоног төхөөрөмж ашиглах талаархи мэдлэг олгох”, “Тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны үндсэн шаардлага, даралтат сав шугам хоолой, өргөх тээвэрлэх машин, механикийн аюулгүй ажиллагаа болон цахилгаан гар багажтай ажиллах аюулгүй ажиллагааны мэдлэг олгох”, “Ажлын байрны аюулгүй ажиллагааны 3 шатны зааварчилгаа”-ны сургалтуудыг зохион байгуулж, 43 засварчин, 10 шалгах механик, 8 тэрэг тавигч нийт 61 хүнийг хамруулсан.

Дэлхий нийтэд нүүрлээд буй /Covid - 19/ вирусын цар тахлын онцгой дэглэмтэй холбогдуулан Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол болон Нийслэлийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/166 дугаар захирамжийн дагуу Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын конторын барилга байгууламж, I, II баазуудын контор, объектууд болон тээврийн хэрэгслүүдэд **MNS-5161-3 2002** чанарын стандартын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг Ирланд улсад үйлдвэрлэгдсэн “Клорсепт-17” 0.02%-н уусмалаар мэргэжлийн байгууллага болох Шинэ ариусгал ХХК-аар давхардсан тоогоор 34,366 м2 талбайг хамарсан объектууд, 1,497 тээврийн хэрэгсэлд дараах байдлаар хийлгэсэн болно. Үүнд:

2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр 7,654 м2 талбай бүхий арван нэгэн объект, 247 тээврийн хэрэгсэлд

2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 7,654 м2 талбай бүхий арван нэгэн объект, 269 тээврийн хэрэгсэлд

2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 7,654 м2 талбай бүхий арван нэгэн объект, 247 тээврийн хэрэгсэлд

2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 7,654 м2 талбай бүхий арван нэгэн объект, 249 тээврийн хэрэгсэлд

2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 269 тээврийн хэрэгсэлд тус тус ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 1 дүгээр бааз 3,750 м2 талбай, 150 тээврийн хэрэгсэлд

2020 оны 12 дугаар сарын 06-нд 1 дүгээр бааз 66 тээврийн хэрэгсэлд тус тус ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

Цар тахлыг дотооддоо алдаж, хатуу хөл хорионы дэглэм тогтож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан тээврийн хэрэгсэлд дотоодын нөөц бололцоогоор өдөр бүр ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж, хяналт тавин ажиллаж 25.7 сая төгрөгийн халдвар, хамгааллын хувцас хэрэгсэлийг олгож ажилласан.

**Тусгагдсан зорилт:** Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлын хүрээнд ТББК-ийг 90 хувиас бууруулахгүй ажиллах, техникийн сааталтай цагийг багасгаж, замд эвдэрсэн тэрэгний тоог бууруулж ажиллах. Байгууллагуудын объектуудын инженерийн шугам сүлжээний найдварт ажиллагааг хангаж ажиллах.

Хөдөлмөр эрхэлж байгаа ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварыг хэвээр хадгалж, эрүүл аюулгүй орчинд хөдөлмөрлөх нөхцлөөр хангах, аюул ослоос урьдчилан сэргийлэх

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Нийт хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан ба ТББК 89,83 хувь, техникийн сааталтай цаг 111 цаг болсон. Биелэлт 90 хувь.

Техникийн хэлтсийн хэмжээнд /хэлтсийн ХАБЭААлба, Ерөнхий механикийн албанд давхцсан тоогоор 26 ажил төлөвлөж 100 хувийн биелэлттэй 19 ажил, 90 хувийн биелэлттэй 1 ажил, 80 хувийн биелэлттэй 1 ажил, 60 хувийн биелэлттэй 1 ажил, 50 хувийн биелэлттэй 1 ажил, 0 хувийн биелэлттэй 3 ажил, нийт 4-н төрлийн 125 ажил төлөвлөж ажлын биелэлт 90,02 хувь гүйцэтгэлтэй байна.

Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний найдварт ажиллагааг хангах зорилгоор засварын ажлыг өөрсдийн хүчээр, дотоод нөөц бололцоог ашиглан гүйцэтгэсэн. Биелэлт 90 хувь

Ус, цахилгааны эрсдэл үүсгэх нөхцлийг илрүүлэн тухай бүр зөрчлийг арилгасан. Эрүүл мэндийн нэгдсэн үзлэг, хортон мэрэгч устгах ажил байгууллагын санхүүгийн боломжоос шалтгаалан дараа жил хийгдэхээр хойшлогдсон. Тус зорилгын хүрээнд 4 ажил хийхээр төлөвлөснөөс 3 ажил нь бүрэн хэрэгжиж, 1 ажил нь хэрэгжээгүй. Биелэлт 75 хувь.

Аюул ослоос урьдчилан сэргийлэх анхан шатны болон давтан зааварчилгааг тогтмол өгч хэвшсэн. Биелэлт 100 хувь

2020 онд манай алба нь сургалтын алба болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтран 7-н төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж /Covid-19/ цар тахлын улмаас 2 сургалт цуцлагдаж, 5 сургалт явагдаж 75 хувийн биелэлттэй байна.

Дундаж үнэлгээ 86,67 хувьтай байна.

**Хүрсэн үр дүн:** ТББК өмнөх оноос 0,88 хувиар дээшилж 89,83 хувь болсон, техникийн сааталтай цагийн тоо өмнөх оны мөн үеээс 374,15 цагаар буурсан, замд эвдэрсэн тэрэгний тоо өмнөх оны мөн үеээс 26-аар буурсан үзүүлэлттэй байна. 1, 2-р баазад ашиглагдаж байгаа засвар үйлчилгээний тоног төхөөрөмжүүдэд эвдрэл гэмтэл гараагүй байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдаж, байгууллагад ашиглагдаж байгаа өндөр даралтын болон өргөх буулгах механизмын ашиглалтаас болж аливаа нэгэн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчил доголдол гараагүй.

1-р Баазын засварчин А.Цэндноров 2-р гаражийн хойд талбайд 1-041 автобусны жолооч Ганхуягийн гуйлтаар хийг нь гэсгээж байхад жолооч Өлзийбал автобусыг хөдөлгөж амь насыг нь хохироосон харамсалтай осол гарсан.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:**

Байгууллагын серверт IP camer, File sharing, Spark зэргийн хэвийн ажиллагааг хангасан. Камерын бичлэгийг цаг тухайд нь шүүн ажилласан. Серверийн их цэвэрлэгээг хийлээ.

УБСК ХХК-тай хамтран шинээр суулгасан online хяналтын төхөөрөмжүүдэд засвар болон холболтын ажлыг хийж, 218 автобусыг хяналтын төвтэй холбон ажилласан.

Жи Мобайл ХХК-ний ажилчидтай хамтран 150 автобусанд байрлуулсан сим картуудад шалгалт хийж, 20 дугаарын зөрчлийг арилгаж ажилласан. Мөн нэмэлтээр 20 ш дата дугаарын гэрээ байгуулж ажилласан. Ашиглах боломжгүй болсон компьютер, принтерүүдийг акталж техникийн тодорхойлолт гарган ажилласан. Ковид 19 вирус гарсантай холбоотойгоор хурал цуглааныг онлайнаар хийх тоног төхөөрөмжийг бэлдэж ажиллуулсан. Нийслэлийн мэдээлэл технологийн газраас 9 ш тоон гарын үсгийн төхөөрөмж авч, захиргаа удирдлагын хэлтэст хүлээлгэн өгсөн. Нэгтгэл болон 1,2-р баазуудад компьютерүүдэд 100 ш касперски анти вирусны хамгаалалт суулган аюулгүй ажиллагааг ханган ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20дугаар зүйлийн 1.10 дахь хэсэг, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг үндэслэн байгууллагын захирлын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/20 тоот тушаалаар УБСК ХХК-ний камерын хяналтын тоног төхөөрөмж шинэчлэгдсэнтэй холбогдуулан тус байгууллагын 1, 2-р баазуудын автобусанд суурилуулах тоног төхөөрөмжийг тоолж баталгаажуулах, ажил хүлээлцэх комисс томилсон.

УБСК ХХК-ний техник тоног төхөөрөмж шинэчлэгдсэнтэй холбогдуулан Удирдлага мэдээллийн цахим тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хүрээнд баазуудын тээврийн хэрэгсэлд тоног төхөөрөмж суурилуулах зорилгоор автобусанд ашиглагдаж байгаа онлайн DVR, SD карт, 4 ш камер, түлш хэмжигч тоног төхөөрөмж, техникийн аюулгүй ажиллагааг шалган баталгаажуулах комиссыг 2020 оны 03 сарын 16-ны өдрийн А/19 тоот тушаалаар томилсон. Мөн баазуудын жолооч нарт камерын хяналтын тоног төхөөрөмжүүдийг хүлээлцүүлэх зорилгоор жолооч нарт автобусны камер 4 ш, онлайн DVR, SD карт, түлш хэмжигч тоног төхөөрөмжүүдийг хүлээлцэх комиссыг захирлын 2020 оны 03 сарын 16-ны өдрийн А/16 тоот тушаалаар томилсон.

2020 оны 03 дугаар сарын 04 нд байгууллагын захирлын өгсөн үүргийн дагуу Орлогч захирлын өрөөнд ДХШХ-ийн ажилтнуудтай хуралдаж 2019 оны 10 сарын 23-наас эхлэн УБСК ХХК-ний суурилуулж байгаа камерын хяналтын тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтын ажлын явц, хүлээлцэх, хариуцах эзэн, хяналтын ажилтнуудын хяналт хийж байгаа байдал зэрэгтэй танилцсан. Хурлаас ажлын явцыг хурдавчлах, 2 бааз дээр тоног төхөөрөмж хүлээлцэх ажлын хэсэг гаргаж актаар хүлээлцэж ажиллах талаар шийдвэрлэсэн.

2020 оны 03 дугаар сарын 10 нд УБСК ХХК-ний үйл ажиллагааны газрын дарга Р.Ган-Эрдэнэ, Мэдээлэл технологийн газрын дарга Чойр Юн Мин, Засвар үйлчилгээний хэлтсийн дарга Е.Хулан нартай нэгтгэлийн ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдсан. Хурлаар засвар үйлчилгээний болон хяналтын гэсэн 2

ажлын хэсэг баазуудад ажиллуулж камерийн хяналтын онлайн төхөөрөмжийг эцэслэн суурилуулж актаар хүлээн авахаар болсон.

2020 оны 03 дугаар сарын 11-нээс 03 сарын 16-ныг дуустал 1 дүгээр баазын нийт 150 ш ДЭҮ БС-106 маркийн автобусанд онлайн хяналтын тоног төхөөрөмж суурилуулах ажлын хэсэг ажиллаж 142 тээврийн хэрэгслийг бүрэн болгон хүлээлгэн өгсөн ба өнөөгийн байдлаар 1 тээврийн хэрэгсэл засвартай /1-065/, SD карт гэмтэлтэй /1-005, 1-023, 1-071, 1-074, 1-135/, алга болсон /1-034, 1-126/ түлш хэмжигч эвдсэн /1-143/ гэсэн 8-н тээврийн хэрэгсэл байна. Ашиглалтын алба жолооч нарт 142 тээврийн хэрэгсэл хүлээлцсэн.

Ажлын хэсэг 2020 оны 03 дугаар сарын 12 нд 1-012 дугаартай автобусанд түлшний бак дүүргэж хэмжилт хийж 185 л багтаамжтай гэж үзэн программ дээр дээд хязгаарыг тэмдэглэхээр болсон.

2020 оны 03 дугаар сарын 16-наас 03 сарын 27-ныг дуустал 2 дугаар баазын 70 ш ДЭҮ БС-106 автобус, 20 ш МА3 угсраа автобусанд онлайн хяналтын тоног төхөөрөмж суурилуулах ажлын хэсэг ажиллаж байна. Өнөөгийн байдлаар 67 тээврийн хэрэгсэлд тоног төхөөрөмж суурилуулж 60 тээврийн хэрэгсэл жолооч нарт хүлээлцсэн. SD карт алга болгосон /2-087, 2-097, 2-114/, SD карт гэмтэлтэй /2-076, 2-089, 2-099, 2-110, 2-126, 2-131, 2-138/, /2-118, 2-131/ хуучин DVR солих 12 гэсэн тээврийн хэрэгсэл байгаа ба 20 ш угсраа автобусны сим карт суурилуулж ажилд оруулахаар төлөвлөн ажиллаж байна. УБСК ХХК-тай 20 ш МА3 угсраа автобусны сим картыг ажилд оруулбал тоног төхөөрөмжүүдийг хүлээлцэхээр ажиллаж байна.

Байгууллагын хэмжээнд 04 сарын 01-ний байдлаар нийт 220 тээврийн хэрэгслээс 214 тээврийн хэрэгсэлд онлайн DVR, SD карт, 4 ш камер, түлш хэмжигч тоног төхөөрөмжүүдийг суурилуулж актаар хүлээж авч, жолооч нарт гарын үсгээр хүлээлгэж өгөөд байна.

Тоног төхөөрөмж суурилуулаагүй дутуу тээврийн хэрэгсэл:

1-р бааз 1 тээврийн хэрэгсэл /1-065 төхөөрөмж шатсан/

2-р бааз 5-н тээврийн хэрэгсэл /2-087, 2-097, 2-114 SD картгүй боловч бичлэг шууд хянах боломжтой, 2-118, 2-131 хуучин DVR-ыг онлайн болгож солих/

УБСК ХХК-тай 2020 оны 04 дүгээр сарын 01 нд “Онлайн камер ашиглалтын гэрээ”-г хийж тоног төхөөрөмжүүдийг актаар хүлээлцэн хоёр талаас баталгаажуулж ажиллаа.

2020 оны 04 сарын 06-наас эхлэн 1-р баазын тээврийн хэрэгслийн камерын байрлал, түлшний датчик зэргийг хөдөлгөөнгүй байлгах зорилгоор тоног төхөөрөмжүүдийг нааж эхэлсэн ба 04 сарын 13-ны байдлаар 73 тээврийн хэрэгслийг наасан байна. Мөн 04 сарын 22-ны байдлаар нийт 149 тээврийн хэрэгслийг бүрэн нааж дуусгасан.

УБСК ХХК-ын суурилуулсан түлшний датчикийн мэдээллийг үнэн зөв гаргах үүднээс тээврийн хэрэгслийн түлшний бак хэмжиж эхэлсэн.

Үүнд: 2020 оны 04 сарын 07 нд 1-100 автобусны түлшний бакийг хүсээр нь хоосолж, дараа нь ШТС дээр дүүргэхэд 180 л болсон. Мөн 1-070 автобусыг ШТС дээр

бакийг хоосолж дараа нь дүүргэхэд 179,8 л орсон. 2-р бааз дээр хэмжилт хийхэд 2-073 194 л, 2-102 191 л гэсэн дүүргэлттэй байсан. Бакны хэмжээ урт 101 см, өргөн 59 см, өндөр 34 см байсан.

Дараа нь 2020 оны 04 сарын 09 нд хоёр бааз хэмжилт хийсэн автобуснуудаа хооронд нь сольж хэмжихэд 1-р бааз дээр хэмжилт хийсэн 2-102 189,12 л, 2-р бааз дээр хэмжилт хийхэд 1-070 178,37 л хэмжээтэй гарсан. Автобуснууд ирсэн хугацаанаас хамаарч бакны хэмжээ өөр өөр байна гэж үзэж болохоор байна. Иймд график дээр автобус бүрийн түлшний дүүргэлтийн хэмжээг өөр өөр хэмжээтэй тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

2020 оны 04 сарын 15 нд 1-р бааз дээр 2-073 автобусны түлшний бакыг хэмжиж үзсэн. Түлшний бакыг хүйсээр нь хоосолж 5 литрийн багтаамжтай хэмжих саваар 5-н удаа буюу 25 л түлш хийж, нэмж ШТС-аас дүүргэхэд 159,52 л түлш орж бак дүүрсэн буюу нийт баканд 184,52 л түлш орж дүүрсэн.

2020 оны 05 сарын 06-наас эхлэн 2-р баазын тээврийн хэрэгслийн камерын байрлал, түлшний датчик зэргийг хөдөлгөөнгүй байлгах зорилгоор тоног төхөөрөмжүүдийг нааж 05 сарын 08 нд бүрэн дуусгасан. Цаашид тээврийн хэрэгслийн түлшний датчыг программ дээр үнэн зөв заадаг болгохын тулд нарийвчилсан туршилт, программын шинэчлэлт хийх шаардлагатай гэж үзэж байна.

4.2 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй 400 автобусанд утаа бууруулагч төхөөрөмж суурилуулсан ажлын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 321 дүгээр тогтоолын хавсралт болох **ТӨРӨӨС АВТОТЭЭВРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО (2018-2026)** баримт бичгийн хүрээнд БНСУ-ын ITEM CHEONGOOK Co.,Ltd компанид үйлдвэрлэсэн E NOM утаа бууруулах төхөөрөмжийн техник технологийн ашиглалтын горим, аюулгүй ажиллагаа, эдийн засгийн үр ашгийн тооцоолол, экологийн нөлөөлөл зэрэг чиглэлүүдээр туршилт, судалгааны ажлуудыг хийж, нэгдсэн дүгнэлт, үр дүнг Зам тээврийн, хөгжлийн сайдын дэргэдэх Техникийн асуудал эрхэлсэн хороонд танилцуулах, эрх бүхий байгууллагын оношилгооны дүгнэлт гарсан тохиолдолд хамтарч ажиллахад татгалзах зүйлгүй гэсэн утгатай албан бичиг 2020 оны 01 дүгээр сарын 31 нд хүргүүлсэн.

2020 оны 01 сарын 17 нд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албаны зөвлөх Ц.Банзрагч тэргүүтэй ажлын хэсгийн төлөөлөл байгууллага дээр ирж утаа бууруулах төхөөрөмжийн талаар танилцуулсан.

Манай байгууллагын хүргүүлсэн албан бичгийн хариуд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос “Утаа бууруулагч төхөөрөмж суурилуулах ажлын удирдамжийг хэрэгжүүлэхийг шаардах тухай” гэсэн 2020 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 2020/29 тоот албан бичиг ирүүлсэн.

Албан бичиг болон “Нийслэлийн нийтийн тээврийн тээврийн үйлчилгээнд явж буй 400 автобусанд утаа бууруулагч төхөөрөмж суурилуулах ажлын удирдамж”-ийн хэрэгжилтийг хангуулах үүднээс Орчны бохирдлыг бууруулах ажлын албаны зөвлөх Ц.Банзрагчтай холбогдон 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр ДЭУ БС-106 маркийн 5-н автобусанд утаа бууруулах төхөөрөмжийг суурилуулах, суурилуулсны дараа Сонгино Хайрхан Дүүргийн автотээврийн хэрэгслийн оношилгооны төвд оношилгоо хийлгэн тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарч байгаа утааг хэрхэн бууруулж байгаа талаар дүгнэлт гаргуулж цаашид бусад тээврийн хэрэгсэлд хэрэгжүүлж хамтран

ажиллахаар тохиролцсон ба энэ тухай албан бичгийг 2020 оны 02 дугаар сарын 11 нд хүргүүлсэн.

Эхний ээлжинд 5-н тээврийн хэрэгсэлд төхөөрөмж суурилуулж АТҮТ ТӨҮГ-ын оношилгооны төвөөр хэмжилт хийлгэсэн. 10 хоногийн дараа Төслийн багаас хэмжилт дахин хийлгэн үр дүнг танилцуулсны дараа бусад тээврийн хэрэгсэлд суурилуулах талаар тохиролцсон боловч дээрх ажил хийгдээгүй.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй 400 автобусанд утаа бууруулагч төхөөрөмж суурилуулах ажлын удирдамж”-ийн 5 дахь заалтын “Ажил үүргийн хуваарь” хэсгийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын үүрэгт:

1. Тоног төхөөрөмж суурилуулах багийг саадгүй нэвтрүүлэх, түргэн шуурхай ажиллах нөхцөлөөр хангах
2. Нийтийн тээврийн 400 автобусны насжилт, он, марк болон хөдөлгүүрийн төрөл, бусад мэдээллийг нэгтгэн гаргаж Үндэсний хороонд ирүүлэх
3. Утаа бууруулах төхөөрөмж суурилуулах Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ болон бусад ААН, байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллах гэж заасан.

Удирдамжийн заалтын дагуу тоног төхөөрөмж суурилуулах баг хуйлруулагч суурилуулах, нэгтгэлийн зүгээс график гарган тээврийн хэрэгслээ бэлдэж цаашид хамтран ажиллахаар болсон.

Өнөөгийн байдлаар удирдамжийн хэрэгжилт хангагдаагүй, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны төхөөрөмж суурилуулах ажлын хэсэг ажиллаагүй. Энэ ажлыг үр дүнтэй байлгах зорилгоор өөрсдийн ИТА-нуудын хүчээр дээрх төхөөрөмж суурилуулах ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Аливаа төсөл хөтөлбөр хэрэгжилт тооцсон тайлан, дүгнэлттэй байх ёстой гэж үзэж байгаа тул улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах тал дээр БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо анхаарал хандуулах шаардлагатай гэсэн албан бичиг өгсөн.

Энэ хугацаанд:

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020/02 тоот албан бичигт 2020 оны 01 сарын 31 нд 2/99 тоот хариу хүргүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020/29 тоот албан шаардлагад 02 сарын 11 нд 1/133 тоот албан шаардлагын хариу хүргүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн.

2020 оны 03 сарын 26 нд БОАЖЯ-д нөхцөл байдлын талаар илтгэх хуудас хүргүүлсэн. Байгууллага өөрсдийн ИТА, засварчдын нөөц бололцоогоор төхөөрөмж суурилуулах ажлыг хийж эхэлсэн.

2020 оны 05 сарын 08-ны байдлаар 1-р бааз 43, 2-р бааз 60, нийт 103 тээврийн хэрэгсэлд хуйлруулагч төхөөрөмж суурилуулсан.

2020 оны 05 сарын 13-ны байдлаар 2-р бааз 70, 2020 оны 05 сарын 28-ны байдлаар 1-р бааз 49 нийт 119 тээврийн хэрэгсэлд хуйлруулагч төхөөрөмж суурилуулсан.

2020 оны 06 сарын 05-ны байдлаар 1-р бааз 95 тээврийн хэрэгсэлд хуйлруулагч суурилуулсан.

Эдгээр албан бичгүүдийн шаардлагуудын дагуу байгууллагын 2009 онд БНСУ-д үйлдвэрлэсэн ДЭУ БС-106 маркийн 185 автобусанд утааны тортогжилтыг бууруулах, бүрэн шаталтыг дэмжих төхөөрөмжийг суурилуулсан.

Утаа оношилгооны дүгнэлт

2020 оны 05 сарын 05 нд АТҮТ-өөс мэргэжилтэн Тэмүүжин ирж хуйлруулагч суурилуулсан 1-119, DPF шүүлтүүр суурилуулсан 1-144 дугаартай тээврийн хэрэгсэлд утааны тортогжилтын оношилгоо хийсэн.

2020 оны 05 сарын 11 нд ЗТХЯ-ны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга н.Жаргалсайхан, ахлах мэргэжилтэн н.Хабидолда, АТҮТ-ийн Техникийн хэлтсийн дарга М.Эрдэнэдалай, мэргэжилтэн н.Тэмүүжин, инженер Н.Мөнхсүх, техникч Д.Доржсүрэн, НТҮГ-ын орлогч дарга н.Мөнхбаяр, ахлах мэргэжилтэн С.Нямдорж нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг СХД-ийн явуулын оношилгооны Старекс маркийн 00 74 УБМ улсын дугаартай Явуул-1 автомашинтай ирж хуйлруулагч төхөөрөмж суурилуулж байгаа байдалтай газар дээр нь танилцсан. Мөн хуйлруулагч суурилуулсан 1-053 гараж дугаартай автобусны утааны тортогжилтыг шалгалаа. Шалгалтаар:

Хуйлруулагч төхөөрөмж суурилуулсан үед: 20,1 хувь хэмжээтэй, хуйлруулагч төхөөрөмж суурилуулаагүй үед 22,1 хувийн тортогжилтын хэмжээг багажаар зааж байсан.

Япон Улсын Жайка олон улсын байгууллагын шугамаар DPF утаа шүүх төхөөрөмж суурилуулсан 1-016 гараж дугаартай автобус дээр туршилт хийхэд шүүлтүүргүй горимын үед 19,0, шүүлтүүртэй горимын үед 12,6 хувийн тортогжилтын хэмжээг багаж дээр зааж байсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд н.Цэрэнбатад 2020 оны 03 дугаар сарын 26 нд 1/326 тоот албан бичгээр “Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй 400 автобусанд утаа бууруулагч төхөөрөмж суурилуулах ажлын удирдамж”-ийн дагуу төхөөрөмж суурилуулах ажлын явцын тухай илтгэх хуудсыг хүргүүлсэн.

Илтгэх хуудсанд “Аливаа төсөл хөтөлбөр хэрэгжилт тооцсон тайлан, дүгнэлттэй байх ёстой гэж үзэж байгаа тул улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай” гэсэн санал хүргүүлсэн боловч албан ёсоор хариу ирүүлээгүй.

2020 оны 05 дугаар сарын 11 нд ЗТХЯ-ны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга н.Жаргалсайхан, ахлах мэргэжилтэн н.Хабидолда, АТҮТ-ийн Техникийн хэлтсийн дарга М.Эрдэнэдалай, мэргэжилтэн н.Тэмүүжин, инженер Н.Мөнхсүх, техникч Д.Доржсүрэн, НТҮГ-ын орлогч дарга н.Мөнхбаяр, ахлах мэргэжилтэн С.Нямдорж нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг СХД-ийн явуулын оношилгооны Старекс маркийн 00 74 УБМ улсын дугаартай Явуул-1 автомашинтай ирж хуйлруулагч төхөөрөмж суурилуулж байгаа байдалтай газар дээр нь танилцаж, 1-016, 1-053 зэрэг автобусууд дээр хэмжилт хийсэн. Шалгалтаар:

Хуйлруулагч төхөөрөмж суурилуулсан үед 1-053 автобус 20,1 хувь хэмжээтэй, хуйлруулагч төхөөрөмж суурилуулаагүй үед 22,1 хувийн тортогжилтын хэмжээг багажаар зааж байсан.

Япон Улсын Жайка олон улсын байгууллагын шугамаар DPF утаа шүүх төхөөрөмж сурилуулсан 1-016 гараж дугаартай автобус дээр туршилт хийхэд шүүлтүүргүй горимын үед 19,0, шүүлтүүртэй горимын үед 12,6 хувийн тортогжилтын хэмжээг багаж дээр зааж байсан.

Зоригч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын хувьд нийт ирсэн 185 ш хуйлруулагч төхөөрөмжийг ДЭУ БС-106 автобусанд суурилуулж гүйцсэн. Хуйлруулагч төхөөрөмж суурилуулсан автобусууд НТҮГ-ын тээврийн хэрэгслийн оношилгооны төвийн хяналтын төхөөрөмжөөр хэмжихэд зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү тортогжилттой байх, шугамын үйлчилгээнд утаатай шалтгаанаар 57 тээврийн хэрэгслийн бичиг баримтаа хураалгасан тохиолдлууд цөөнгүй гарсан.


#### Хүснэгт 1. Утаатай тээврийн хэрэгсэл

| №  | Гараж дугаар | Шугамын үйлчилгээний чиглэл | Шалтгаан | Төх.суурил уулсан огноо | Огноо      | Тайлбар                                            |
|----|--------------|-----------------------------|----------|-------------------------|------------|----------------------------------------------------|
| 1  | 1-019        | Ч:32                        | Утаатай  | 2020.04.09              | 2020.07.30 | БЗД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан     |
| 2  | 1-015        | Ч:32                        | Утаатай  | 2020.06.04              | 2020.08.26 | Шугаманд явуулахгүй гэж Бааз руу буцаасан          |
| 3  | 1-143        | Ч:58                        | Утаатай  | 2020.05.21              | 2020.09.10 | Замын цагдаад бичиг баримт хураалгасан             |
| 4  | 1-023        | Ч:23                        | Утаатай  | 2020.06.09              | 2020.09.22 | Замын цагдаад бичиг баримт хураалгасан             |
| 5  | 1-045        | Ч:63                        | Утаатай  | 2020.04.16              | 2020.09.22 | Замын цагдаад бичиг баримт хураалгасан             |
| 6  | 1-143        | Ч:11                        | Утаатай  | 2020.05.21              | 2020.09.25 | Замын цагдаад бичиг баримт хураалгасан             |
| 7  | 1-106        | Ч:50                        | Утаатай  | 2020.06.02              | 2020.09.25 | Замын цагдаад бичиг баримт хураалгасан             |
| 8  | 1-133        | Ч:23                        | Утаатай  | 2020.04.02              | 2020.10.22 | Шугаманд явуулахгүй гэж Бааз руу буцаасан          |
| 9  | 1-023        | Ч:66                        | Утаатай  | 2020.06.09              | 2020.11.04 | ХУД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан     |
| 10 | 1-028        | Ч:26                        | Утаатай  | 2020.06.09              | 2020.11.08 | БЗД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан     |
| 11 | 2-133        | Ч:57                        | Утаатай  | 2020.05.01              | 2020.05.28 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан     |
| 12 | 2-086        | Ч:57                        | Утаатай  | 2020.05.05              | 2020.07.29 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт ху14раалгасан   |
| 13 | 2-121        | Ч:9                         | Утаатай  | 2020.04.30              | 2020.08.11 | ХУД15-ийн Замын цагдаад бичиг баримт ху16раалгасан |
| 14 | 2-100        | Ч:9                         | Утаатай  | 2020.04.30              | 2020.08.24 | ХУД-ийн Зам18ын цагдаад бичиг баримт ху19раалгасан |
| 15 | 2-086        | Ч:57                        | Утаатай  | 2020.05.05              | 2020.09.11 | СХД20-ийн Замын цагдаад бичиг баримт ху21раалгасан |
| 16 | 2-093        | Ч:9                         | Утаатай  | 2020.05.11              | 2020.09.23 | ХУД-ийн Зам23ын цагдаад бичиг баримт ху24раалгасан |
| 17 | 2-126        | Ч:57                        | Утаатай  | 2020.04.30              | 2020.09.23 | СХД25-ийн Замын цагдаад бичиг баримт ху26раалгасан |
| 18 | 2-140        | Ч:57                        | Утаатай  | 2020.04.30              | 2020.09.24 | СХД-ийн Зам28ын цагдаад бичиг баримт ху29раалгасан |
| 19 | 2-080        | Ч:57                        | Утаатай  | 2020.05.05              | 2020.09.24 | СХД30-ийн Замын цагдаад бичиг баримт ху31раалгасан |
| 20 | 2-071        | Ч:57                        | Утаатай  | 2020.05.07              | 2020.09.24 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан     |
| 21 | 2-138        | Ч:57                        | Утаатай  | 2020.05.07              | 2020.09.24 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан     |

|    |       |                   |         |            |            |                                                |
|----|-------|-------------------|---------|------------|------------|------------------------------------------------|
|    |       |                   |         |            |            | бичиг баримт хураалгасан                       |
| 22 | 2-111 | Ч:57              | Утаатай | 2020.05.06 | 2020.09.24 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан |
| 23 | 2-133 | Ч:57              | Утаатай | 2020.05.01 | 2020.09.24 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан |
| 24 | 2-132 | Ч:57              | Утаатай | 2020.05.04 | 2020.09.24 | СХД-ийн Замын цагдаад бичиг баримт хураалгасан |
| 25 | 1-044 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.03.19 | 2020.04.18 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 26 | 1-109 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.21 | 2020.05.19 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 27 | 1-105 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.09 | 2020.04.09 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 28 | 1-129 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.15 | 2020.04.15 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 29 | 2-079 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.01 | 2020.04.02 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 30 | 2-081 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.01 | 2020.04.02 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 31 | 2-083 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.02 | 2020.04.04 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 32 | 2-092 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.01 | 2020.05.06 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 33 | 2-094 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.30 | 2020.05.08 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 34 | 2-107 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.01 | 2020.04.03 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 35 | 2-116 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.01 | 2020.05.13 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 36 | 2-118 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.05 | 2020.05.12 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 37 | 2-130 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.30 | 2020.05.01 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 38 | 2-132 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.04 | 2020.05.05 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 39 | 2-133 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.01 | 2020.05.05 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 40 | 2-137 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.04 | 2020.05.09 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 41 | 2-138 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.07 | 2020.05.08 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 42 | 2-140 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.30 | 2020.05.24 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 43 | 2-073 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.12 | 2020.10.07 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 44 | 2-076 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.31 | 2020.11.12 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 45 | 2-079 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.01 | 2020.10.21 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 46 | 2-082 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.02 | 2020.09.23 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 47 | 2-084 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.06 | 2020.10.27 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 48 | 2-086 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.05 | 2020.10.22 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 49 | 2-089 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.12 | 2020.11.06 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 50 | 2-096 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.12 | 2020.10.28 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 51 | 2-100 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.30 | 2020.11.11 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 52 | 2-102 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.01 | 2020.10.10 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 53 | 2.103 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.04.30 | 2020.10.17 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 54 | 2-108 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.01 | 2020.11.04 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |
| 55 | 2-118 | НТҮГ-ын оношилгоо | Утаатай | 2020.05.05 | 2020.11.04 | НТҮГ-ын оношилгоонд утаагаар тэнцээгүй         |

|    |       |                      |         |            |            |                                           |
|----|-------|----------------------|---------|------------|------------|-------------------------------------------|
| 56 | 2-125 | НТҮГ-ын<br>оношилгоо | Утаатай | 2020.05.04 | 2020.10.23 | НТҮГ-ын оношилгоонд<br>утаагаар тэнцээгүй |
| 57 | 2-140 | НТҮГ-ын<br>оношилгоо | Утаатай | 2020.04.30 | 2020.10.17 | НТҮГ-ын оношилгоонд<br>утаагаар тэнцээгүй |

Дээрх утааны тортогжилтыг бууруулах, бүрэн шаталтыг дэмждэг гэх төхөөрөмжийн үр дүнгийн талаар мэргэжлийн байгууллагаар судлуулж дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзсэн.



#### 4.3 Гамшгаас хамгаалах ажлын талаар:

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 06-наас 08-ны өдрүүдэд “Коронавируст (КОВИД-19) цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын үеэр үүрэг гүйцэтгэх, бэлэн байдлыг хангах зорилгоор Баазуудын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу томилогдсон “Аврах бүлэг”-т зарлан мэдээлэл хүргэж 1-р бааз 9 хүний бүрэлдэхүүнтэй, 2-р бааз 14 хүний бүрэлдэхүүнтэй бэлэн байдалтай ажиллаа.

Байгууллагын хэмжээнд шугамын үйлчилгээний нийт 280 тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг 1-р бааз 96 хувьтай, 2-р бааз 91 хувьтай хангаж бэлтгэл тээврийн хэрэгслийн нөөцөнд бэлдэж ажиллаа.

#### 4.4 Шинэ корона вирусын тархалтаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

Олон улсын нийтийн тээврийн холбоо Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч компаниудад тусламж үзүүлэх зорилгоор Шинэ корона вирусын тархалтаас урьдчилан сэргийлэхэд дасан зохицоход зориулан веб сүлжээнд суурилсан онлайн семинарыг 2020 оны 04 дүгээр сарын 23 нд эхлүүлсэн. ОХУ-д 04 дүгээр сарын 21 нд 11.30 цагаас 13.30 цаг /Москва хотын цагаар/ хүртэл гуравдах удаагийн веб сүлжээнд суурилсан онлайн семинар болсон. Семинарын сэдэв:

- COVID-19 вирусын цар тахлын үед Нийтийн тээврийн үйлчилгээнд шинэ технологи хэрэглэх нь.
- Вирусын цар тархалтын үед ямар шинэ бүтээл, санаа ашиглан ажиллаж байгаа талаар хэлэлцүүлэг өрнүүлэх.

- Цар тахлаас өмнөх жилүүдийг багтаасан ямар шинэ технологийн хамаарал ба хэрэглээ шаардлагатай талаар нотолсон шийдлийн талаар гэх мэт.

Энэ веб сүлжээнд суурилсан онлайн семинар нь Олон улсын нийтийн тээврийн холбооны гишүүдэд үнэгүй хүрч байгаа ба семинарын үеэр асуух асуултуудыг хэдийн чинээ эрт илгээнэ төдий чинээ сайн бэлтгэгдэнэ гэсэн зорилтоор бэлтгэгдсэн.

Танилцуулгатай үзүүлэн материалын хугацаа 1,5 цаг, Илтгэгч нарын танилцуулгын талаар санал асуулга, хэлэлцүүлэгийн хугацаа 30 минут болсон. Онлайн семинарын ерөнхий зохион байгуулагч Олон улсын нийтийн тээврийн холбооны Москва дахь менежер Юсуп Хасиев

Олон улсын нийтийн тээврийн холбооны Евро Азийн сектор хариуцсан нарийн бичгийн дарга, Москва хотын нийтийн тээврийн төслийн ерөнхий захирал Александр Поляков

РАТП-ын олон улсын харилцаа хамтын ажиллагааны ерөнхий удирдлагын Париж дахь хэлтсийн удирдагч Наташа Ферье

Сбербанкны робот техникийн лабораторийн удирдагч Альберт Ефимов

Системийн технологийн ерөнхий захирал Константин Туминас

Семинарын хэлэлцүүлэгт Баку хотын нийтийн тээврийн агентлаг, Москва хотын метро, Петербург хотын метро болон Яндекс такси компаний төлөөлөл цар тахлын үед ажиллаж байгаа арга барил, шинэ технологи нэвтрүүлж байгаа ажлын талаар туршлага хуваалцаж санал солилцлоо.

Онлайн семинарт нийт 64 орноос холбогдож оролцсон гэсэн мэдээг өгсөн. Веб сүлжээнд суурилсан онлайн семинарт оролцох талаар НЗДТГ-аас мэдэгдсэний дагуу Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер, ТХ-ийн дарга Б.Энхцаг, МТИ Л.Мөнхдалай нар 16.30 цагаас 18.45 цаг хүртэл оролцож илтгэлүүдтэй танилцсан.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 16 нд Орлогч даргын өрөөнд захирлын зөвлөл хуралдаж доорх чиглэлүүдэд анхаарч ажиллах талаар үүрэг даалгаврууд өглөө. Үүрэг даалгаврын биелэлтийг баазын удирдлагууд хангаж ажиллах. Үүнд:

1. Байгууллагын ажиллагсадын утасны дугаар шинэчлэх
2. Өдөр тутам ажилласан ажиллагсадын тоог нэгтгэж гаргах, мэдээлэх.
3. Автобусны жолоочийн кабин тусгаарлах /Жолоочийн кабиныг зорчигчдоос тусгаарлах скоч, гялгар цаас худалдан авч өгөх/
4. Эмх цэгц, зохион байгуулалтыг сайжруулж ажиллах
5. Маск, жавилин, бок, саван, резин бээлий, хамгаалах хэрэгслээр хангах
6. Шалгагчийг хамгаалалтын хувцсаар хангах
7. Угаалга, цэвэрлэгээ, ариутгалыг чанартай хийж гүйцэтгэх
8. СД картыг бүрдүүлэх, камер хяналтын систем шалгах, хяналт тавих
9. Автобусны эцсийн буудлуудад хийж буй ариутгал, цэвэрлэгээг сайн зохион байгуулах
10. Автобусанд зорчигчийн зай барьж суух санамжийг бүрэн хэвлэж, автобус нэг бүрт байршуулах
11. Шаардлагатай сэлбэг материалаар бүрэн хангаж ажиллах
12. Бааз, байгууллага дээр жолооч, шалгагч нарын бөөгнөрөл их байгааг таслан зогсоож, зай барьж харьцах, бөөгнөрч зогсохгүй байх талаар анхааруулга

санамж өгч, тамхины цэг, жолоочийн амрах байруудад санамж, анхааруулга хадаж байршуулах

### 13. Жижүүр, эргүүл гаргаж ажиллуулах

Жич: 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс шугамын үйлчилгээний гаралт нэмэгдэх тул хүн хүч, техникийн бэлэн байдлыг зөв зохион байгуулж, оновчтой хуваарилж ажиллах зэрэг үүрэг даалгаврууд өгч ажилласан.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед байгууллагын захирлын зөвлөл, удирдлагууд нийт 2020 оны 11 дүгээр сарын 16, 17, 19, 25 нд нийт 4-н удаа онлайн болон бусад хэлбэрээр хуралдаж хэлтэс, баазуудад дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийг ажилдаа хэрэгжүүлж ажиллахыг даалгасан.

2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 1, 2-р баазын Баазуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу “Гамшгаас хамгаалах тухай хаууль болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах шуурхай бүлгийн зааварчилгаа” гарган Монгол Улсын засгийн газрын 178 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг Даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 тоот “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамж зэргийг хавсарган баазуудын ээлжийн инженер дээр байрлуулав.

2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр НТҮГ-ын Улсын байцаагч н.Сүхбаатар, Шинэ ариусгал ХХК-ний ажилтнуудтай ирж 1-р Баазын 145, 2-р Баазын 125 тээврийн хэрэгсэлд өндөржүүлсэн тунгаар ариутгал хийсэн.

2020 оны 11 дүгээр сарын 18 нд гэрээсээ ажиллах болсон Ерөнхий механик Ш.Цэрэндагва “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой онлайн горимд ажиллах Ерөнхий механикийн ажлын төлөвлөгөө”-г баталсан.

НТҮГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/1328 тоот “Үүрэг, чиглэл өгөх тухай” албан бичгийн дагуу ХАБЭААХА-ны дарга П.Цогт-Эрдэнэ, 1-р Баазын ХАБЭААХА Х.Буяндэлгэр нар 1-р Баазын, ХАБЭААХА Ө.Бор, Ч.Балгансүрэн нар 2020 оны 11 дүгээр сарын 19-нөөс эхлэн өглөө оройн “А” жижүүрийн үйлчилгээнд хүн нэг бүрийн 1,5-аас 2 м зай барьж ажиллаж байгаа, амны хаалт хэрэглэсэн байдалд хяналт тавин ажиллаж байна.

НЗД-ын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 02-04/6486 тоот иргэдийн зорчих хөдөлгөөнийг нарийвчлан гаргах үүднээс иргэний цахим үнэмлэхнийн QR кодыг ашиглан иргэдийн зорчилтын бүртгэлийг хянах <https://qr.ulaanbaatar.mn/> системийг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан ажил зохион байгуулах гэсэн албан бичгийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн 1, 2-р баазуудад нэвтрэх хүмүүсийг иргэний үнэмлэхний QR код уншуулж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

2020 оны 12 дугаар сарын 03-ны өглөө 06:45 цагт 4:23 чиглэлд шугамын үйлчилгээнд гарсан 1-041 автобусны жолооч Ганхуяг хөлдсөн гэсэн шалтгаанаар бааз руу Ээлжийн инженер Батбаяр, шалгах механик Болдбаатар нарт шалгуулалгүй орж ирсэн ба ЗҮС 2-р гаражийн хооронд талбайд зогсон засварчин талийгаач А.Цэндноровтой уулзан хийн системийн хөлдөлт гэсгээлгэхээр автобус доогуур оруулан газар үлээлгэсэн ба автобусаа асаалттай нь орхин явсан. /Няраваас техникийн спирт авахаар/ Энэ үед 1-106 автобусны жолооч Өлзийбал гаражаас автобусаа гаргахад саад болсон тул автобусыг нягтлалгүйгээр хөдөлгөж засварчны амь насыг хохироосон. Замын цагдаагийн газрын жижүүрийн шуурхай бие бүрэлдэхүүнд осол гарсан талаар мэдээлж хэргийн газрын үзлэг хийлгэсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах, инженер техникийн ажилтан, жолооч, засварчдын ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор “Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах тухай” НТҮГ-ын даргын 01 тоот 6-н зүйл заалттай албан даалгавар 2020 оны 12 дугаар сарын 03 нд ирүүлсэн.

Байгууллагын 1-р баазын жолоочоос Корона вирусын шинж тэмдэг илэрсэнтэй холбоотойгоор 2020 оны 12 сарын 03 нд 1-р баазын шугамын үйлчилгээг зогсоосон ба нэмж 1 жолоочид шинж тэмдэг илэрсэн.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжсэнтэй холбогдуулан Коронавируст халдвар /Ковид - 19/-н цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 12 сарын 04 нд НТҮГ-ын даргын “Үүрэг, чиглэл өгөх тухай” 11-н заалттай албан бичиг ирүүлсэн.

Байгууллагын 532 хүнд 12 сарын 03-наас 04 нд шилжих шөнө хурдавчилсан шинжилгээ, 12 сарын 05 нд PSR шинжилгээ өгсөн. Мөн 12 сарын 11 нд PSR-ын давтан шинжилгээг өгсөн. Нэмж сэжигтэй тохиолдол илрээгүй.

Нийслэлийн онцгой комиссоос Коронавируст /Ковид – 19/-н халдвараас сэргийлж өдөр тутмын үйл ажиллагаандаа дотоод хяналт тавьж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэсэн 11-н зүйл заалттай зөвлөмжийг 2020 оны 12 дугаар сарын 05 нд ирүүлсэн.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжсэнтэй холбогдуулан Коронавируст халдвар /Ковид – 19/-н цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 12 дугаар сарын 06 нд НТҮГ-ын даргын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” гэсэн 02 тоот 10-н зүйл заалттай албан даалгавар ирүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Гамшгаас хмагаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэсэн захирамж ирүүлсэнтэй холбогдуулан 1-р баазын 149 тээврийн хэрэгслийг 2 удаа ариутгаж 2020 оны 12 дугаар сарын 14-ний

| №  | Огноо     | Албан тушаал  | Төлбөр | Гэрээний хугацаа |
|----|-----------|---------------|--------|------------------|
| 1  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 2  | Чинзор    | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 3  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 4  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 5  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 6  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 7  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 8  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 9  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 10 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 11 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 12 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 13 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 14 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 15 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 16 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 17 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 18 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 19 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 20 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |

| №  | Огноо     | Албан тушаал  | Төлбөр | Гэрээний хугацаа |
|----|-----------|---------------|--------|------------------|
| 1  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 2  | Чинзор    | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 3  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 4  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 5  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 6  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 7  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 8  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 9  | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 10 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 11 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 12 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 13 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 14 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 15 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 16 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 17 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 18 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 19 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |
| 20 | Сүхбаатар | Төрийн хяналт | 1.50   | 2020.12.14       |

өдрөөс нийтийн тээврийн үйлчилгээнд хэвийн ажиллуулж эхэлсэн.

“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 1, 2-р баазад 2020 оны 12 дугаар сарын 03 ны өглөөний 06 цаг 40 минутын орчим авто тээврийн осол гарч хүний амь нас эрсдсэнтэй холбогдуулан 2020 оны 12 сарын 14-ний өдөр засварчдад “цахилгаан

гар багаж болон бага оврын тоног төхөөрөмж аюулгүй ажиллагаа”, “ажлын байрны нэгээс нөгөөд шилжих, шинэ тоног төхөөрөмж ашиглах талаархи мэдлэг олгох”, “тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны үндсэн шаардлага, даралтат сав шугам хоолой, өргөх тээвэрлэх машин, механикийн аюулгүй ажиллагаа болон цахилгаан гар багажтай ажиллах аюулгүй ажиллагааны мэдлэг олгох”, “Ажлын байрны аюулгүй ажиллагааны 3 шатны зааварчилгаа”-ны сургалтуудыг зохион байгуулж, 43 засварчин, 10 шалгах механик, 8 тэрэг тавигч нийт 61 хүнийг хамруулсан.

Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсээс “Коронавирус /covid – 19/ халдварт өвчин гарсантай холбогдуулан авч хэрэгжүүлэх ажлын удирдамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 08 нд, Техникийн хэлтсээс “Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1-р Баазын хашаан дотор хүний амь нас автобусанд дайруулж эрсдсэнтэй холбогдуулан ажлын байрны хариуцлага дээшлүүлэх, хэлтэс албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлын удирдамж”-ийг байгууллагын захирлаар батлуулан хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Мөн 2020 оны 12 дугаар сарын 17 нд “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн /бүх нийтийн/ бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан ажиллаж байна. 1-р Баазын Техникийн албанд доорхи үүргүүдийг өгч ажиллаа. Үүнд:

1. Ээлжийн инженер шалгах механикийн байранд “Байгууллагын хөдөлгөөнийг зохицуулах журам”-ыг байрлуулах
2. Засварчдын өдөр тутмын зааварчилгаанд “Зориулалтын суваг, ажлын байр талбайд тээврийн хэрэгслийн доогуур орж засвар үйлчилгээ хийх” гэсэн нэмэлт заалт оруулах
3. Засварын технологи ажилбарыг дэлгэц дээр гаргаж технологийн дарааллыг засварчинд танилцуулж ажилд оруулах

ХОК-ийн хүснэгтийг самбарт ил байрлуулж, засварчны ажлыг дүгнэж танилцуулах зэрэг үүрэг даалгаврууд өгч удирдамжийн дагуу төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг даалгалаа.

4.5 ТХ-ийн хэмжээнд нийт 99 ирсэн, явуулсан 123 баримт бичгийн шийдвэрлэлтийг хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Одоогоор хугацаа хоцорсон, хариу өгөөгүй бичиг байхгүй байна.

**Тусгагдсан зорилт:** Байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.

#### **Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

Автобусанд сурилуулсан онлайнаар хянах тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Биелэлт 100 хувь.

Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй 400 автобусанд утаа бууруулагч төхөөрөмж суурилуулах удирдамжийн дагуу 185 автобусанд төхөөрөмж суурилуулсан. Биелэлт 90 хувь.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсээс “Коронавирус /Covid – 19/ халдварт өвчин гарсантай холбогдуулан авч хэрэгжүүлэх ажлын удирдамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 08 нд, Техникийн хэлтсээс “Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 1-р Баазын хашаан дотор хүний амь нас автобусанд дайруулж эрсдсэнтэй холбогдуулан ажлын байрны

хариуцлага дээшлүүлэх, хэлтэс албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлын удирдамж"-ийг байгууллагын захирлаар батлуулан хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Мөн 2020 оны 12 дугаар сарын 17 нд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн /бүх нийтийн/ бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулан ажилласан. Биелэлт 90 хувь.

ТТБТХ-т ирсэн, явсан бичгүүдийн бүрдэлийг хугацаанд нь бүрдүүлж, хугацаа хоцроосон бичиг байхгүй байна. Биелэлт 100 хувь.

Дундаж үнэлгээ 95 хувьтай байна.

**Хүрсэн үр дүн:** Байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласнаар иргэд, олон нийт, бусад байгууллагад үйл ажиллагаагаа сурталчилж мэдээллийн нээлттэй байдал ил тод болсон.

## **ТАВДУГААР БҮЛЭГ: БУСАД МЭДЭЭЛЭЛ**

### **5.1 Техник технологи бодлого төлөвлөлтийн хэлтсийн хурлын талаар:**

Техник технологи бодлого төлөвлөлтийн хэлтсийн хурлыг 2020 онд нийт 4-н удаа хийлээ. Үүнд:

1. Техник технологи бодлого төлөвлөлтийн хэлтсийн хурал 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хуралдаж 2020 оны 01 сарын 03-нд өглөө үүрээр 04:25 цагийн үед 2-р гаражид байрлаж байсан 1-065 автобусны арын хэсгээс гарсан галын нөхцөл байдал, ээлжийн ажилтнуудын ажлын хахриуцлага, эрсдлээс сэргийлэх талаар өгсөн үүрэг даалгавар, биелэлт хэлэлцэх, Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг асуудлуудыг авч хэлэлцсэн.
2. ТТБТХ хэлтсийн хурал 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдсан. Техник технологи бодлого төлөвлөлтийн хэлтсийн нийт ИТА, засварчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, санал хүсэлт хүргэх талаар авч хэлэлцэж, цалинг тодорхой хувиар нэмэгдүүлэх саналыг байгууллагын захирлын зөвлөлд танилцуулахаар шийдвэрлэсэн.
3. 2020 оны 1-р сард тус 1, 2-р баазын ЦХА, ТТА-ны 13-н засварчинд цахилгаан автобусны ашиглалт онолын талаар "Нарны зам" сургалтын төв, БНХАУ-н "YIN LONG" үйлдвэрийн хятад мэргэжилтэнүүд 3 хоногийн сургалт явуулсан. Засварчны зэрэг олгох, сургалт явуулах ажлын хэсэг 2020 оны 01 дүгээр сарын 28 нд хоёр баазын 13 засварчнаас мэдлэг шалгах, зэрэг ахиулах шалгалтыг ЗТН-ийн "Засварчны зэрэг олгох, сургалт явуулах журам"-ын дагуу комиссын бүрэлдэхүүнтэй "Нарны зам" сургалтын төвд амжилттай зохион байгуулсан.
4. 2020 оны 10 дугаар сарын 23 нд ХАБАЭАХА-ны ажилтнуудыг цуглуулан "ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ" ОНӨААТҮГ-ын эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гүйцээх, Цахилгаан хангамжийн албаны засварчид, Шалгах механикууд, Засварын инженерүүдийн ажлын байрны хэвийн бус нөхцлийн үнэлгээ хийлгэх, хөдөлмөр хамгааллын хувцасны хангалт хийлгэх талаар хурал зохион байгуулсан.

### **5.2 Цахилгаан автобусны ашиглалтын талаар:**

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК болон БНХАУ-ын автобусны Ин Лунг үйлдвэр хоорондын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн С/12 дугаартай "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн дагуу 2019 оны 12 дугаар сард

үйлдвэрлэсэн GTQ6126BEVBT20 загварын 10 ш цахилгаан автобусыг туршилтын журмаар ашиглах болсон.

Цахилгаан автобус турших асуудлаар хамтран ажиллах гэрээний дагуу байгууллага дээр 8 ш цахилгаан автобус ирсэн 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 04 сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд цахилгаан автобусыг шугамын үйлчилгээнд туршсан ажлын тайланг нэгтгэсэн. Үүнд:



Автобусны ажиллагаа. 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 14:30 цагийн үед Олон улсын тээвэр зуучийн төвийн гаалийн баталгаат агуулахад буусан 8 ш цахилгаан автобус 2 ш автобус цэнэглэдэг цахилгаан моторыг хүлээн авсан.

2020 оны 01 дүгээр сарын 09-нөөс 01 дүгээр сарын 16-ныг дуустал УБХХК ХК-ийн АТҮТ-д өгөх улсын дугаар, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгуулах, мөн эд хөрөнгө түр хүлээлцэх актыг 8 ш цахилгаан автобус, 2 ш цэнэглэгч мотор дээр үйлдэж хүргүүлсэн. Япон улсын Засгийн газрын тусламжаар суурилуулсан ЗҮС-ын 400 кВт чадалтай трансформаторын хэрэглэгчийг чөлөөлж 1-р бааз дээр цахилгаан автобус цэнэглэх 360 кВт-ын цэнэглэх төхөөрөмжийг дангаар нь залгах зорилгоор 1-р баазын кузов засварын цех болон 1, 2-р гаражуудын цахилгаан эрчим хүчний хэрэглээг КТП 569-өөс сэлгэн залгасан. Автобусны хүч дамжуулах анги /карданы боолт, дугуйн шпилька чангалгаа/ хөргөлтийн шингэний шлангны хомут чангалгааг засварчин Ганзориг, До.Энхбат, Шинэбаяр, Засварын инженер Энхмэнд, Цэнд нар гүйцэтгэв. ЗҮСтанц, 2-р конторын цахилгаан эрчим хүчний хэрэглээг 300 м цахилгааны кабель шугам татан ТП 244-өөс сэлгэн залгасаны үндсэнд автобус цэнэглэгчээ байршуулж ЗҮС-ын трансформаторт холбон автобус цэнэглэхэд бэлдэв. Автобуснуудыг нэг нэгээр нь Засвар үйлчилгээний станцад оруулан үзлэг шалгалт, тестлэх ажлуудыг эхлүүлэв.


2-р бааз цахилгаан автобус цэнэглэгчийг Засварын Депогийн КТП-1-ийн 630 кВА трансформаторт холбон автобус цэнэглэхэд бэлэн болгосон.

Мөн 2020 оны 01 дүгээр сарын 16-наас 01 дүгээр сарын 24-ны хугацаанд нийт 6-н удаа туршилтын байдлаар шугамын чиглэлд ажилласан. Хоёрдох ээлжийн туршилтыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос эхлэн 02 дугаар сарын 01-нийг хүртэл шугамын үйлчилгээний 14-н чиглэлүүдэд байгууллагын ИТА болон бусад ажиллагаадыг автобусанд суулган хийсэн.

2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 8-н автобусыг өдөрт нэг автобус 3-н рейс гүйцэтгэхээр шугамын үйлчилгээний Ч:1, Ч:59 чиглэлд ажиллуулсан.

2020 оны 04 дүгээр сарын 18-наас эхлэн Ч:1 чиглэлд 2 ээлжийн жолоочтойгоор бүтэн өдрийн турш үйлчилгээ үзүүлэхээр Нийтийн тээврийн үйлчилгээний газраар график батлуулан ажиллаж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын баталсан графикаар Ч:1 чиглэлийн эргэлтийн урт 24 км, эргэлтийн хугацаа 1:50 цаг ба цахилгаан автобус ажлын өдөр өглөөд 3-н рейс, оройд 3-н рейс гүйцэтгэж, 1 рейсэнд дунджаар 20 км нийт 70 гаруй км зай туулж, цахилгаан батарей 16-аас 43 хувийн цэнэгийн үлдэгдэлтэй баазуудад ирж өдөр болон оройд хоёр удаа бүрэн цэнэглэлт хийж байна.



Хурлын мэдээлэл. Байгууллагын захирлын баталсан ажлын хэсэг 2020 оны 01 дүгээр сарын 16 нд, 01 дүгээр сарын 22 нд, 01 дүгээр сарын 27 нд НТҮГ-ын мэргэжилтэнг оролцуулан, 01 дүгээр сарын 31 нд НТҮГ, УБХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр мөн 02 дугаар сарын 04 нд буюу 5-н удаа хуралдаж цаг үеийн ажлын талаар болон хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх талаар шийдвэр гаргаж ажилласан.

Мөн 2020 оны 02 дугаар сарын 11 нд НЗД-ын гаргасан А/178 тоот захирамжийн дагуу “Нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэгчийн байршлыг судалж, тодорхойлох, санал боловсруулах” үүрэг бүхий 11-н газрын ажлын хэсэг хуралдаж цэнэглэгч байршуулах газрын давхцал, цахилгаан эрчим хүчний техникийн боломж, замын ачаалалд нөлөөлөх нөлөөлөл, нийтийн тээврийн үйлчилгээний шугамын зохион байгуулалт зэрэг асуудлыг судалж нэгтгэн дүгнэлт гаргаж НИТХ-д танилцуулах санал гаргахаар шийдвэрлэж ажилласан.

Байгууллагын захирлын баталсан ажлын хэсгийн 7 дахь удаагийн хурал 2020 оны 03 дугаар сарын 10 нд, хуралдаж 2 асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж ажилласан. Үүнд:

1. 2020 оны 02 дугаар сарын 11 нд НЗД-ын гаргасан А/178 тоот захирамжийн дагуу “Нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэгчийн байршлыг судалж, тодорхойлох, санал боловсруулах” үүрэг бүхий өргөтгөсөн ажлын хэсэг хуралдаж цэнэглэгч байршуулах 12 газрын давхцал, цахилгаан эрчим хүчний техникийн боломж, замын ачаалалд нөлөөлөх нөлөөлөл, нийтийн тээврийн үйлчилгээний шугамын зохион байгуулалт зэрэг асуудлыг судалж нэгтгэн дүгнэлт гаргаж НИТХ-д танилцуулах санал гаргахаар тогтсон. Үүний дагуу холбогдох газруудад санал хүргүүлсэн. Нийслэлийн газрын албатай холбоотой хийгдэх ажлууд гарсан учир байгууллагын Аж ахуйн менежерийг томилж газрын кадастрын зураг, холбогдох баримтуудыг бүрдүүлж Нийслэлийн газрын албаар хянуулж зохих өөрчлөлтийг хийлгэн өөр хувь хүн, ААН-тэй давхцалгүй газрын зураг гаргуулж авахаар болсон ба ажил үргэлжилж байна.
2. Цахилгаан автобусанд ажиллаж байгаа жолооч нарын цалингийн талаар өдөрт шугаманд ажиллаж байгаа цаг нь 3-аас 4-н цаг байгааг бүтэн 8-н цагаар бодож тооцох. Амралтын өдрийн ажилласан цагийг илүү цагт нэмж тооцохоор шийдвэрлэсэн.

Цэнэглэгч байршуулах 12 газрын талаар мэдээлэл. Зорчигч тээврийн нэгтгэлийн 1 болон 2-р баазууд дээр 10,10 ш цэнэглэх станц төсөвлөхөд тус бүр 3600 кВА чадал шаардлагатай байна. 1000 кВА-гаас дээш чадлын техникийн нөхцлийг Эрчим хүчний яам, ЦДҮС ТӨХК-ийн хамтарсан комиссын хурлаар эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэдэг тул ажлын хэсэгт холбогдох гишүүдийг оролцуулан шийдвэрлэх шаардлагатай байдаг. Өнөөгийн байдлаар 2-р баазын цэнэглэх цэгийн цахилгааны хэрэглээний чадлын техникийн нөхцөл гарсан, 1-р баазын нөхцөл судлагдаж байна. Шугамын үйлчилгээний маршрутын дагуух цэнэглэгчийн байрлалууд:

1. ХУД 3-р хороо. БММЗ эцсийн автобус цэнэглэх станц.

Холболтын цэг: 35/6 кВ-ын “Эсгийлэх” дэд станцаас 6 кВ-ын ТТС-9 А,Б фидерийн ТТС-9 дэд өртөөний трансформаторын чадлыг 2\*400 кВА 6/0,4 кВ-ын трансформатораар солих.

Чадал: 360 кВт.

Хийгдэх ажил: ТТС-9 дэд өртөөний трансформаторыг өргөтгөж 0.4 кВ-ын кабель шугам татаж тэжээх. Ойролцоо төсөв: 45.0 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Шаардлагатай тохиолдолд Эсгийлэх дэд станцын оролт кабелийг шинэчлэн солих. Нийтийн тээврийн 10-н чиглэлийн 100 автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 6-н чиглэлийн 46-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 4-н чиглэлийн 54-н автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 7 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

2. СХД 18-р хороо. 5-н шарын эцсийн буудлын автобус цэнэглэх станц.

Холболтын цэг: Үйлдвэр дэд станцын 10 кВ-ын РП-22-ын ТТС-6 дэд станцын I ба II секцнээс кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП барих

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 2\*800 м кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 389.5 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Мөн ТТС-6 дэд станцын РП-22 оролт А, Б кабелийг ачаалалд тохируулан зураг төслийн дагуу шинэчлэх. Нийтийн тээврийн 8-н чиглэлийн 95 автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 3-н чиглэлийн 24-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 5-н чиглэлийн 71-н автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 6 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

### 3. БЗД 1-р хороо. Сансрын тойргийн автобус цэнэглэх станц

**Холболтын цэг:** РП-24-өөс 10 кВ-ын Сансар А,Б фидерийн ХТП-1446,306 хоорондох А,Б кабель шугам татаж шинээр барих 2\*400 кВА дэд өртөөний 10 кВ-ын I ба II секцээр оруулж гаргах тэжээх.

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 4\*100 м кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 237.8 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 6-н чиглэлийн 51 автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 1 чиглэлийн 9-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 5-н чиглэлийн 42 автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 3 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

### 4. БЗД 8-р хороо. Ботаникийн эцсийн автобус цэнэглэх станц

**Холболтын цэг:** 110/35/10 кВ-ын Туул дэд станцын 10 кВ-ын ТТС-2 А,Б фидерийн ТТС-2 дэд станцын I ба II секцнээс кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП барих

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 2\*1100 м кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 411.4 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 10-н чиглэлийн 99 автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 6-н чиглэлийн 58-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 4-н чиглэлийн 41-н автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 7 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

### 5. ХУД 16-р хороо. Нисэхийн эцсийн автобус цэнэглэх станц

**Холболтын цэг:** 110/35/10 кВ-ын Яармаг дэд станц, ХБ-44-өөс 10 кВ-ын ТП17 А,Б фидерийн ХТП-4057 хоорондох кабель шугамуудыг таслаж ижил маркийн кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөний 10 кВ-ын I ба II секцийг оруулж гарган тэжээх.

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 4\*75 м кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 228.1 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 4-н чиглэлийн 40 автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 3-н чиглэлийн 27-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 1 чиглэлийн 13-н автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 2 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

6. СХД 9-р хороо. Баянхошууны хуучин эцсийн автобус цэнэглэх станц  
Холболтын цэг: 35/6 кВ-ын Ваар дэд станцын 6 кВ-ын Баруун салаа фидерийн 23-р тулгуураас кабель шугам татаж 400 кВА чадалтай бетонон хийцтэй, 3 ачаалал таслагч бүхий КТПН барих.

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 100 м кабель шугам татаж 400 кВА чадалтай КТПН дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 76.0 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 5-н чиглэлийн 56-н автобус дайран өнгөрдөг. Эхний ээлжинд 1 ш, цаашид 4 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

7. ЧД 6-р хороо. Баянбүрд автобус цэнэглэх станц

Холболтын цэг: 110/10/6 кВ-ын Умард дэд станцын 6 кВ талын ТТС ячейкнаас кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП барьж тэжээх.

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 550 м кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 259.4 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 5-н чиглэлийн 71-н автобус дайран өнгөрдөг. Эхний ээлжинд 1 ш, цаашид 5 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

8. БЗД 9-р хороо. Шархадны эцсийн автобус цэнэглэх станц

Холболтын цэг: 110/10/10 кВ-ын Улаанхуаран дэд станцын 10 кВ-ын I ба II секцнээс кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП барьж тэжээх

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 2\*1000 м кабель шугам татаж 2\*400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 392.1 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 4-н чиглэлийн 66-н автобус дайран өнгөрдөг. Эхний ээлжинд 1 ш, цаашид 4 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

9. ХУД 1-р хороо. Наадам центр автобус цэнэглэх станц

Холболтын цэг: 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын 10 кВ талаас тэжээгддэг ТТС дэд станцын 10 кВ талаас кабель шугам татаж 400 кВА чадалтай бетонон хийцтэй, 3 ачаалал таслагч бүхий КТПН барьж тэжээх.

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 300 м кабель шугам татаж 400 кВА чадалтай ХТП дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 122.9 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Мөн ТТС-ын Өмнөд дэд станцын оролт кабелийг ачаалалд тохируулан зураг төслийн дагуу шинэчлэн солих. Нийтийн тээврийн 11-н чиглэлийн 108-н автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 7-н чиглэлийн 74-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 4-н чиглэлийн 34-н автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 7 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

10. СБД 14-р хороо. 7 буудлын эцсийн автобус цэнэглэх станц

**Холболтын цэг:** 110/35/10 кВ-ын Сэлбэ дэд станцын Согоот фидерийн 18-р тулгуураас кабель шугам татаж 400 кВА чадалтай бетонон хийцтэй, 3 ачаалал таслагч бүхий КТПН барьж тэжээх.

Чадал: 360 кВт

Хийгдэх ажил: Шинээр 10 кВ-ын 200 м кабель шугам татаж 400 кВА чадалтай КТПН дэд өртөө барих.

Ойролцоо төсөв: 86.9 сая

Тайлбар: ЦДҮС ТӨХК-иас санал авах, 0.4 кВ-ын кабель шугамын зардал тооцоолоогүй. Нийтийн тээврийн 6-н чиглэлийн 52 автобус дайран өнгөрдөг. Үүнээс ЗТН-ийн 1 чиглэлийн 10-н автобус, бусад аж ахуйн нэгжийн 5-н чиглэлийн 42 автобус үйлчилж байна. Эхний ээлжинд 1 ш, цаашид 3 ш цэнэглэгч байршуулах шаардлагатай.

Бусад аж ахуйн нэгжийн 6-н чиглэлийн 59 автобус цэнэглэгч цэгүүдийн байршилд очихгүй байна. Бусад ААН-дэд мэргэжлийн хувьд илүү боломжоо ашиглан өөрсдийн ЦХА-ны ажиллагсадын мэргэжлийн ур чадварт тулгуурлан дээрх цэнэглэх цэгүүдийг шинээр суурилуулах боломжтой гэж үзэж байна.

Засварын мэдээлэл. 2020 оны 04 дүгээр сарын 27-ныг дуустал хугацаанд ИТА болон жолооч нарын зүгээс 4-н удаа кузов аваар гаргасан. Үүнд:

1. 2020 оны 01 сарын 17 нд засварын инженер Цэнд өглөө “А”-аар 2-142 автобусыг ЗҮС-ын талбай чөлөөлж ухарч гаргах гэж байгаад баруун хойд булан сэвтүүлсэн. Будуулж бэлэн болгосон.

2. 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдөр 2-142 Ганбаяр ажил үүрэг гүйцэтгэж явах үед саппорогийн буудлын орчим хажуугаас жижиг тээврийн хэрэгсэл мөргөж хойд буланг сэвтүүлсэн. Техникийн үзлэг хийж актыг гаргаж, засварлаж хэвийн болгосон.
3. 2020 оны 04 сарын 21 өглөө 2-142 Ганбаяр 6.42 цагт 5-н шарын автобусны буудал дээр ухарч байгаад арын шил хагалсан.
4. 2020 оны 04 сарын 27 нд 15.25 цагт Лабораторийн хуучин буудлаас жижиг тэрэг гарч ирж арын буфер мөргөсөн.

Сэлбэг сольсон хүснэгт

| Он сар | 1-151                  | 1-152                  | 1-153                  | 1-154                  | 1-141                    | 1-142 | 1-143                     | 1-144                         |
|--------|------------------------|------------------------|------------------------|------------------------|--------------------------|-------|---------------------------|-------------------------------|
| 01.24  |                        |                        |                        |                        |                          |       | Тосолгооны шланг          |                               |
| 01.31  | Пийшин релей, мэдрэгч  |                        |                        |                        |                          |       |                           |                               |
| 02.04  | Пийшин асаалтын датчик | Пийшин асаалтын датчик | Пийшин асаалтын датчик |                        |                          |       |                           |                               |
| 02.06  |                        |                        |                        |                        | мэдрэгч                  |       | Пийшингийн релей, мэдрэгч | мэдрэгч                       |
| 02.07  |                        |                        |                        |                        |                          |       |                           | Тос.аппарат, Тосолгооны шланг |
| 02.14  | Богино мэдрэгч         | Богино мэдрэгч         |                        |                        |                          |       |                           |                               |
| 02.15  |                        |                        |                        | Баттарей хатаасан      |                          |       |                           |                               |
| 02.20  |                        |                        | Тосолгооны шланг       |                        |                          |       |                           |                               |
| 03.09  |                        |                        |                        |                        | Хаалганы хий хуваарилагч |       |                           |                               |
| 04.05  |                        |                        |                        |                        | Тэжээлийн нэмэх кабель   |       |                           |                               |
| 04.09  |                        |                        |                        |                        |                          |       | Хий хувиарлагч            |                               |
| 04.19  | Тэжээлийн нэмэх кабель |                        |                        | Тэжээлийн нэмэх кабель |                          |       |                           |                               |
| 04.24  |                        | Тэжээлийн нэмэх кабель |                        |                        |                          |       |                           |                               |
| Нийт   | 5                      | 3                      | 2                      | 2                      | 3                        |       | 4                         | 3                             |

Энэ хугацаанд 1-151 5880 км гүйлттэй, цахилгаан автобусанд 5-н төрлийн 5 ш сэлбэг,

1-152 6019 км гүйлттэй, цахилгаан автобусанд 3-н төрлийн 3 ш сэлбэг,

1-153 5608 км гүйлттэй, цахилгаан автобусанд 2-н төрлийн 2 ш сэлбэг,

1-154 5501 км гүйлттэй, цахилгаан автобусанд 2 төрлийн 2 ш сэлбэг,

2-141 5867 км гүйлттэй, цахилгаан автобусанд 3-н төрлийн 3 ш сэлбэг,

2-142 5659 км гүйлттэй, сэлбэг хэрэглээгүй,

2-143 5305 км гүйлттэй, цахилгаан автобусанд 4-н төрлийн 4 ш сэлбэг,

2-144 5779 км гүйлттэй, цахилгаан автобусанд 3-н төрлийн 3 ш сэлбэг буюу нийт 22 төрлийн 22 сэлбэг солигдсон байна. 2-142 автобус сэлбэг солигдоогүй байна.

1-р Баазын 4-н цахилгаан автобусны засвар үйлчилгээ:

2020 оны 04 сарын 08 нд улирлын үйлчилгээгээр нийт автобусны татах хөдөлгүүр, батарейн дулаалгыг тайлж авсан. 2020 оны 04 дүгээр сарын 19 нд ТҮ-1 үйлчилгээ хийж редукторын тос солих, үлээлгэ цэвэрлэгээ хийх, цахилгааны хүчдэл хэмжих, чангалгаа хийх зэрэг ажлууд хийсэн.

ТҮ-1 хийх үеэр 1-151, 1-154 автобусны өндөр хүчдэлийн тэжээлийн нэмэх кабель утас сольсон. 2020 оны 04 дүгээр сарын 24 нд 1-152 автобусны өндөр хүчдэлийн тэжээлийн нэмэх кабель утас сольсон.

2-р баазын 4-н цахилгаан автобусны засвар үйлчилгээ.

2020 оны 04 сарын 26 нд улирлын үйлчилгээгээр 4-н цахилгаан автобусны татах хөдөлгүүр, батарейн дулаалгыг тайлж авсан. ТҮ-1 үйлчилгээний үеэр тосолгооны цэгүүдэд тос шахах, редукторын тос солих, үлээлгэ цэвэрлэгээ хийх, цахилгааны хүчдэл хэмжих, чангалгаа хийх зэрэг ажлууд хийсэн.

Цэнэглэгч мэдээлэл. Цахилгаан автобусуудыг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 22-ний өдрийг дуустал нийт 87-оос 90-н удаагийн цэнэглэлт хийсэн бөгөөд автобусны батарейн температураас хамаарч өөр өөр хугацаа зарцуулж байгаа боловч цахилгааны хэрэглээ нь нэг удаагийн цэнэглэлтээр 60-аас 83 кВт эрчим хүч зарцуулж байна.

Цахилгаан автобуснуудын цэнэглэлтийн хэмжээ үлдэгдэл цэнэгийн хэмжээнээс хамаарч 20-иос 29 минутанд бүрэн цэнэглэгдэж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

| Эрчим хүч зарцуулалт /2020.01.28-2020.04.22-ны байдлаар/ |       |        |        |        |          |
|----------------------------------------------------------|-------|--------|--------|--------|----------|
| Гр№                                                      | Сар   |        |        |        |          |
|                                                          | 1 сар | 2 сар  | 3 сар  | 4 сар  | Нийт кВт |
| 1-151                                                    | 147.6 | 1463.1 | 1783   | 1408.4 | 4802.1   |
| 1-152                                                    | 216   | 1457.4 | 1961.6 | 1485.6 | 5120.6   |
| 1-153                                                    | 216   | 1602.3 | 1623.6 | 1316.8 | 4758.7   |
| 1-154                                                    | 169.6 | 1148   | 1811.6 | 1446.6 | 4575.8   |
| Нийт                                                     |       |        |        |        | 19257.2  |
| Гр№                                                      | Сар   |        |        |        |          |
|                                                          | 1 сар | 2 сар  | 3 сар  | 4 сар  | Нийт кВт |
| 2-141                                                    | 0     | 1605.2 | 1685.2 | 1887.5 | 5177.9   |
| 2-142                                                    | 0     | 1487.8 | 1505.2 | 1444.8 | 4437.8   |
| 2-143                                                    | 0     | 1552.6 | 1343.6 | 1494.8 | 4391     |
| 2-144                                                    | 0     | 1111.8 | 1793.6 | 1446.8 | 4352.2   |
| Нийт                                                     |       |        |        |        | 18358.9  |

2020 он 04 сарын 23 нд 2-р бааз дээр 4-н цахилгаан автобусанд цэнэглэлтийг хэмжиж үзэхэд: Эхний автобус 12.47 цагт ирж цэнэглэсэн.

2-144

цэнэглэсэн хугацаа 20,2 мин. Цэнэгийн үлдэгдэл 43% цэнэглэлт 99% чадал 73,6 кВт,

2-141 цэнэглэсэн хугацаа 22,16 мин. Цэнэгийн үлдэгдэл 18% цэнэглэлт 91% чадал 82,4 кВт,

2-143 цэнэглэсэн хугацаа 21,45 мин. Цэнэгийн үлдэгдэл 16% цэнэглэлт 86% чадал 78,4 кВт,

2-142 цэнэглэсэн хугацаа 20,06 мин. Цэнэгийн үлдэгдэл 41% цэнэглэлт 100% чадал 72,8 кВт. 2-р баазын 4-н автобусны цэнэглэлт 14.20 цагт дууссан буюу нийт 1.33 цаг үргэлжилсэн.

ИТА болон жолооч нараас гарсан Санал хүргүүлсэн талаар. Инлунь үйлдвэрийн үйлдвэрлэлийн менежер Тиан Лейд дараах утгатай бичиг хүргүүлсэн. Үүнд:

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК болон Нийслэлийн Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын хооронд байгуулсан 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Г/27 дугаартай “Цахилгаан автобусыг турших асуудлаар хамтран ажиллах гэрээ”-ний дагуу БНХАУ-ын автобусны Ин Лунь үйлдвэрт үйлдвэрлэсэн GTQ6126BEVBT20 загварын 8-н ширхэг цахилгаан автобусыг түр хүлээн авч шугамын үйлчилгээнд ашиглаж байна.

Эхний ээлжийн туршилтыг 2020 оны 01 дүгээр сарын 16-наас эхлэн хийж эхэлсэн. Хоёрдох ээлжийн туршилтыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос эхлэн шугамын үйлчилгээний чиглэлүүдэд хийж эхэлсэн. Өнөөдрийг хүртэл автобусыг шугамын үйлчилгээнд ашигласан хугацаанд автобуснуудын ажиллагааны талаар Баазуудаас Удаа дараа гарсан саналыг нэгтгэвэл:

- Нийт автобуснуудын батарей цэнэглэлтийн горимд алдаа гарч байгаа байдлыг тодруулах шаардлагатай байна. Тухайлбал 2-141, 2-143 гараж дугаартай автобуснууд шугамын үйлчилгээнд бусдаасаа 20-аас 35 хүртэл хувиар их цэнэг зарцуулсан зөрөөтэй байдал ажиглагдаж байна.
- 2-141 дугаартай автобус өндөрийн тэжээлийн нэмэх кабель утас сольсон боловч цэнэглэлт нь асуудалтай, бүрэн цэнэглэгдэхгүй байна.
- 1-151, 2-141, 2-143 дугаартай автобуснуудын цэнэглэлтийн хошуу 83-аас 97 хувийн заалтанд нэмж цэнэглэхгүй байгаа боловч цэнэглэгч дээр бүрэн цэнэгтэй гэж зааж байгаа тодруулах.
- Зорчигчын заал руу пийшингийн утаа их орж байна. Заалны хана тааз, утаа тортог болсон байна. Энэ асуудлыг шийдэх.
- Автобусны хойд хэсэг хөнгөн дугуйн эргэлт хурдан байгаа тул хальтиргааны үед хий эргэх бөгсөө хаяж шарвах тал ихээр ажиглагдаж байна.
- Пийшингийн релей, дулааны мэдрэгч байнга шатаж байгаа тул сайжруулах шаардлагатай байна.
- Батарейн битүүмж сайжруулах шаардлагатай, ус чийг багатай үед 1-154 дугаартай автобусны батарей чийг авсан нь битүүмж муу байгааг харуулж байна.
- Жолоочийн кабины хаалгыг босготой болгох шаардлагатай байна. /Зорчигчийн шавхай жолоочийн кабинд ихээр урсч орж ирж байна/.
- Галын хорыг урагшлуулж жолоочийн хяналтан дор байрлуулах
- Тосолгооны системийн даралтын шланг чанар муу байгаагийн улмаас задрах байдал ажиглагдаж байна.

Шугамын үйлчилгээний ашиглалтын үед гарсан доголдлуудыг засварлаж сайжруулах, өөрчлөх талаар гарсан эдгээр саналуудыг хэрхэн шийдвэрлэх талаар хариу өгөх зэрэг.

Үйлдвэрийн хариулт. 2-141 和 2-143 车辆耗电量高。2-141, 2-143 автобусны цэнэг зарцуулалт өндөр байгаа шалтгаан:

回复：此问题还未实际测试，具体原因无法确认，待确认后回复。Энэ асуултыг үнэндээ туршиж үзээгүй бөгөөд тодорхой шалтгааныг нь баталж чадахгүй байна. Баталгаажуулсны дараа эргэн хариу өгөх болно.

1. 车辆 2-141 充电时，充电桩电量显示与仪表电量显示不一致。

回复：2-141 充电桩充电电量显示与仪表上电量显示是一致的，后续刷新程序可以解决此问题。2-141 дугаартай автобусанд өндөрийн нэмэх тэжээлийн утас сольсон бөгөөд цэнэглэгч болон автобусны дэлгэц дээрх цэнэгийн хэмжээ зөрүүтэй гарч байгаа ч автобусны дэлгэц дээр 100% гэж гарч байгаа нь хэвийн гэдгийг илэрхийлж байгаа бөгөөд хойшид ийм асуудал гарахгүй байх болно.

2. 1-151, 2-141, 2-143 充电时，充电到 83-97%时，电量充满，系统显示有问题。1-151, 2-141, 2-143 дугаартай автобусны цэнэглэлтийн тухай:

回复：此问题回复同问题 2。Энэ асуудал 2 дугаар асуултын хариулттай ижил болно.

3. 车内有柴油味道。Зааланд пийшингийн түлшний үнэр үнэртэх:

回复：后续车辆更换韩国加热器，可以解决此问题。Хойшид үйлдвэрлэх шинэ автобусанд солонгос брендийн пийшин тавих учир зааланд пийшингийн дизель үнэртэх асуудал гарахгүй.

4. 雪地行驶，后部侧滑。Гулгаж шарвах:

回复：已根据客户实际使用环境，增加 ABS 和 ASR，解决此问题。Цахилгаан автобусны шарвах, гулгах нөхцөлд анхаарч хойшид үйлдвэрлэх автобусанд ABS, ASR тормозны системийг нэмэлтээр тавьж өгнө.

5. 加热器热电偶问题。Пийшингийн релей, дулааны мэдрэгч эвдэрч буй асуудал: 回复：同问题 4，后续车辆更换韩国加热器，可以解决此问题。Энэ нь 4 дугаар асуулттай ижил бөгөөд хойшид солонгос брендийн пийшин тавихад асуудал шийдэгдэнэ.

6. 1-154 电池仓进水问题, 1-154 дугаартай автобусаны батерей чийг авсан асуудал:

回复：由于蒙古地区使用习惯不同，后续在散热器固定处增加翻边挡水，并打胶密封。Заалны паарыг байршуулсан хэсгийн шалны бэхэлгээг сайн хийж силикон цавуугаар нааж өгснөөр батерейн хэсэгрүү ус орох асуудал шийдэгдсэн.

7. 司机区域有水问题。Жолоочийн кабинд ус орж буй байдал:

回复：由于蒙古地区使用习惯不同，后续将司机驾驶区抬高 30mm，避免水流到司机驾驶区域，Хойшид Монголын хэрэглээ шаардлагад тохируулан жолоочийн кабиныг 30мм –ын өндөртөй босготой болгоно.

8. 车内灭火器更换位置。Галын хорын байршил солих:

回复：后续车辆按照客户要求安装。Хэрэглэгчийн шаардлагын дагуу хойд хаалганд байршуулсан галын хорыг урд хаалганы хажууд байршуулсан.

9. 集中润滑高压油管问题。Тосолгооны системийн даралтын шланг:

回复：后续根据蒙古低温环境特点，更换耐低温高压油管。Хойшид үйлдвэрлэх автобусанд хүйтэн нөхцөлд ажиллах боломжтой даралтын шланг ашиглах болно.

Санхүүгийн мэдээлэл. Цахилгаан автобусны зардлын тооцоо

Цахилгаан автобусыг турших хэлэлцээрийн дагуу турших ажлын бэлтгэл ажил цахилгаан автобусны цэнэглэгчийг суурилуулах болон автобусны наалт улсын дугаар авахад нийт 31,120,963 төгрөгийн зардал гарсан байна.

Бэлтгэл ажлын зардлын жагсаалт /төгрөг/

Цахилгаан автобусны үндсэн 8 жолоочийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн ажилуулсан ба туршилтын ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ажлын өдөр шугамын үйлчилгээний цагийг 8 цагаар тооцож бусад нэмэгдлийг цалин хөлсний журмын дагуу их багтаамжийн автобусны цалингийн тарифаар тооцож олгосон. Туршилтын 3 сарын хугацаанд 36.3 сая төгрөгийн цалин 4.9 сая төгрөгийн ажил олгогчийн НДШ-ийн зардал гарсан байна.

|   | Гараж №               | Нийт бодогдсон цалин | Унаа хоолны хөнгөлөлт | Бүгд цалин | НДШ /ажил олгогч/ | Нийт зардал |
|---|-----------------------|----------------------|-----------------------|------------|-------------------|-------------|
| 1 | 113001 - Э.Очирхуяг   | 4,369,179            | 284,000               | 4,653,179  | 628,179           | 5,281,359   |
| 2 | 112011 - Д.Баярсайхан | 4,333,700            | 284,000               | 4,617,700  | 623,390           | 5,241,090   |
| 3 | 111019 - Ш.Мөнхбат    | 3,156,585            | 212,000               | 3,368,585  | 454,759           | 3,823,344   |
| 4 | 114075 - Д.Цогбадрах  | 4,077,560            | 272,000               | 4,349,560  | 587,191           | 4,936,751   |
| 5 | 113016 - Жанлав       | 1,026,878            | 68,000                | 1,094,878  | 147,808           | 1,242,686   |
| 6 | 121093 - Б.Ганбаяр    | 4,291,400            | 288,000               | 4,579,400  | 618,219           | 5,197,619   |
| 7 | 121025 - Э.АлтанОд    | 3,166,325            | 220,000               | 3,386,325  | 457,154           | 3,843,479   |
| 8 | 121043 - Б.Дашням     | 4,234,475            | 284,000               | 4,518,475  | 609,994           | 5,128,469   |
| 9 | 121016 - Б.Мөнхзул    | 3,950,350            |                       |            |                   |             |

|      |                        |                   |                  |                   |                  |                   |
|------|------------------------|-------------------|------------------|-------------------|------------------|-------------------|
|      |                        |                   | 280,000          | 4,230,350         | 571,097          | 4,801,447         |
| 10   | 121012-<br>С.Хадбаатар | 1,386,550         | 96,000           | 1,482,550         | 200,144          | 1,682,694         |
| Нийт |                        | <b>33,993,002</b> | <b>2,288,000</b> | <b>36,281,002</b> | <b>4,897,935</b> | <b>41,178,937</b> |

Цалингийн зардал: Туршилтын хугацаанд цахилгаан автобусны жолооч нийтийн тээврийн үйлчилгээнд ажилласан цаг нь байгаа тул цалингийн зардал их гарч байна. Цаашид 100 хувь шугамын үйлчилгээнд явахад их багтаамжийн автобустай ижил тарифаар цалинжуулах тул цалингийн зардал ижил байна.

Цахилгаан автобус 2020 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс 04 дүгээр сарын 22-ний өдрийг хүртэлх туршилтын хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээнд 1,738.7 цаг ажиллаж 121,737 зорчигч тээвэрлэж 32,041,600 төгрөгийн шугамын үйлчилгээний орлого төвлөрүүлсэн ажилласан байна.

Тухайн хугацааны ажилласан машин цагийг Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 23/14 тоот тогтоолын троллейбусны тарифаар тооцож 51.6 сая төгрөгийг зардлын зөрүү санхүүжилтийн орлого олсон байна.

#### Цахилгаан автобусны үйлчилгээний орлого

|      | Гараж<br>№ | Зорчигчийн<br>тоо | Шугамын<br>орлого<br>/төгрөг/ | Аж цаг         | Санхүүжилтийн<br>орлого /төгрөг/ | Нийт орлого<br>/төгрөг/ |
|------|------------|-------------------|-------------------------------|----------------|----------------------------------|-------------------------|
| 1    | 01-151     | 14,623            | 3,892,100                     | 308.4          | 6,121,031.2                      | <b>10,013,131.2</b>     |
| 2    | 01-152     | 15,777            | 4,113,700                     | 312.6          | 6,035,796.8                      | <b>10,149,496.8</b>     |
| 3    | 01-153     | 14,223            | 3,792,500                     | 302.0          | 6,012,836.0                      | <b>9,805,336.0</b>      |
| 4    | 01-154     | 12,912            | 3,325,000                     | 293.6          | 6,207,604.8                      | <b>9,532,604.8</b>      |
| 5    | 02-141     | 17,429            | 4,643,300                     | 357.7          | 6,969,529.6                      | <b>11,612,829.6</b>     |
| 6    | 02-142     | 15,197            | 3,962,400                     | 353.2          | 7,505,297.6                      | <b>11,467,697.6</b>     |
| 7    | 02-143     | 15,581            | 4,152,000                     | 317.2          | 6,146,849.6                      | <b>10,298,849.6</b>     |
| 8    | 02-144     | 15,995            | 4,160,600                     | 331.0          | 6,586,308.0                      | <b>10,746,908.0</b>     |
| Нийт |            | <b>121,737</b>    | <b>32,041,600</b>             | <b>1,738.7</b> | <b>51,585,253.6</b>              | <b>83,626,853.6</b>     |

Цахилгаан автобусны хэрэглээний шууд зардалд 37,616 квт цахилгаан, дулаацуулгын пийшингийн нэмэгдэлд 4,628 литр дизель түлш хэрэглэж 19.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.

|   | Гараж<br>№ | Зарцуулсан<br>цахилгаан<br>/кв.т/ | Цахилгааны<br>зардал<br>/төгрөг/ | Зарцуулсан<br>шатахуун<br>/литр/ | Шатахууны<br>зардал<br>/пийшингийн<br>нэмэгдэл/ | Нийт зардал |
|---|------------|-----------------------------------|----------------------------------|----------------------------------|-------------------------------------------------|-------------|
| 1 | 01-151     | 4,802                             | 1,046,858                        | 710                              | 1,683,530                                       | 2,730,387   |

|      |        |               |                  |              |                   |                   |
|------|--------|---------------|------------------|--------------|-------------------|-------------------|
| 2    | 01-152 | 5,121         | 1,116,291        | 651          | 1,543,534         | 2,659,824         |
| 3    | 01-153 | 4,759         | 1,037,397        | 637          | 1,510,164         | 2,547,561         |
| 4    | 01-154 | 4,576         | 997,524          | 716          | 1,696,304         | 2,693,828         |
| 5    | 02-141 | 5,178         | 1,128,782        | 380          | 901,003           | 2,029,785         |
| 6    | 02-142 | 4,438         | 967,440          | 473          | 1,120,512         | 2,087,953         |
| 7    | 02-143 | 4,391         | 957,238          | 584          | 1,384,507         | 2,341,745         |
| 8    | 02-144 | 4,352         | 948,780          | 476          | 1,129,068         | 2,077,848         |
| Нийт |        | <b>37,616</b> | <b>8,200,310</b> | <b>4,628</b> | <b>10,968,621</b> | <b>19,168,931</b> |

Шатахууны зардал: Туршилтын 3 сарын хугацаанд нэг цагийн шатахууны зардал 11,024 төгрөг гарсан ба үүнийг их багтаамжийн автобусны шатахууны зардал 14,942 төгрөгөөр тооцогддог. Туршилтын хугацаанд гаднах температур хасах градустай байсан байнгын пийшингийн нэмэгдэл хэрэглэж байснаар шатахуун зардал өндөр гарсан ба жилийн хугацаанд зуны улиралд пийшингийн нэмэгдэл хэрэглэхгүй тул шатахууны зардал 38 хувиар буурч нэг цагийн шатахууны зардал 6,835 төгрөг байх боломжтой гэж тооцож байна.

Цахилгааны автобус нь их багтаамжийн автобусаас шатахуун болон тос, тосолгооны зардалтай харьцуулахад жилийн дүнгээр 65 хувийн хэмнэж ажиллах боломжтой юм.

Санал. Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/178 дугаар захирамжаар нийтийн тээврийн үйлчилгээнд үйлчлэх цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжийн байршлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг эхний ээлжийн 10 байршлыг сонгохдоо цахилгааны тэжээлийн эх үүсвэр, хотын нийтийн тээврийн маршрут төлөвлөлт авто замын урсгал хөдөлгөөн бусад хүчин зүйлтэй уялдуулан хийж төлөвлөсөн.

Иймд дээрх байршлуудыг өөрчлөхгүйгээр газрын хэмжээг хасуулах нийтийн тээврийн маршрутын дагуу маневарлах зам талбай зэргийг тооцоолон ойрхон зайд шилжүүлэн байршуулах зэрэг зохицуулалтыг хийж ажиллаж байна.

Цаашид эдгээр байршлуудад байрлаж байгаа цахилгаан автобусны цэнэглэгчийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага гарах тул цахилгаан байгууламжийн холбогдох хуульд заасан хамгаалалтын бүсийг Нийслэлийн хот төлөвлөлтийн газрын мэдээллийн санд бүртгүүлэх, мөн өргөтгөх хүчин чадлыг нэмэгдүүлэх санал боловсруулж газар олголтын нөөц бүрдүүлэх зорилгоор тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан ажиллах, цэнэглэгчийг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Туршилтын хугацаанд 8-н цахилгаан автобусанд нийт 22 төрлийн 22 сэлбэг солигдсон байна. 2-142 автобус сэлбэг солигдоогүй байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын баталсан графикаар Ч:1 чиглэлийн эргэлтийн урт 24 км, эргэлтийн хугацаа 1:50 цаг ба цахилгаан автобус ажлын өдөр өглөөд 3-н рейс, оройд 3-н рейс гүйцэтгэж, 1 рейсэнд дунджаар 20 км, нийт 70 гаруй км зай туулж 16-аас 43 хувийн цэнэгийн үлдэгдэлтэй баазуудад ирж өдөр болон оройд

хоёр удаа бүрэн цэнэглэлт хийж байна. Цахилгаан автобусны баттарейн температураас хамаарч автобус цэнэглэх үед өөр өөр хугацаа зарцуулж байгаа боловч цахилгааны хэрэглээ нь нэг удаагийн цэнэглэлтээр 60-аас 83 кВт эрчим хүч зарцуулж байна. Цахилгаан автобуснуудын цэнэглэлтийн хэмжээ үлдэгдэл цэнэгийн хэмжээнээс хамаарч 20-иос 29 минутанд бүрэн цэнэглэгдэж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Цахилгааны автобус нь их багтаамжийн автобуснаас шатахуун болон тос, тосолгооны зардалтай харьцуулахад жилийн дүнгээр 65 хувийг хэмнэж ажиллах боломжтой юм.

Цахилгаан автобусны цэнэглэглэгчийг эцсийн буудал болон цэнэглэх дундын цэгүүдэд шийдсэн тохиолдолд Нийслэлийн хэмжээнд цахилгаан автобусаар нийтийн тээврийн үйлчилгээг тасралтгүй найдвартай үзүүлэх бүрэн боломжтой гэж үзсэн.

**Тусгагдсан зорилт:** Шинэ бүтээл оновчтой санаачлагыг дэмжиж ажиллах. Байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгслийг нийтийн тээврийн үйлчилгээнд турших:

#### **Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

ТТБТХ-ийн цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан хэлтсийн хурлыг хийснээр ажлын зохион байгуулалт дээшилж, ажлын хэрэгжилтийг үнэлж тайланд тусгадаг болсон. Биелэлт 100 хувь.

Цахилгаан автобусыг ашиглах, шугамын үйлчилгээнд турших ажил нь шинээр сэлбэг худалдан авах зардлыг тодорхой хэмжээнд хэмнэж эдийн засгийн хэмнэлттэй ажиллаж байгууллагын хувьд зардал хэмнэж ажилласан. Биелэлт 90 хувь.

Дундаж үнэлгээ 95 хувьтай байна.

**Хүрсэн үр дүн:** Байгаль орчинд ээлтэй эко цахилгаан тээврийн хэрэгслийг нийтийн тээврийн шугамын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр нийслэлийн хүрээлэн буй орчин, агаарын бохирдол, хүн амын эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөх томоохон дэвшилтэт ажил болсон.

#### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ**

Техникийн хэлтсийн хэмжээгээр тусгагдсан зорилтын хэмжээнд 2020 онд хэлтсийн төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын дундаж үнэлгээ 90,02 хувьтай байна.

ТХ-ийн хэмжээгээр тусгагдсан зорилтын хэмжээнд 2020 онд хийж хэрэгжүүлсэн ажлын дундаж нь:

А. Нэгдүгээр бүлэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн дундаж биелэлт 89,3 хувь

Б. Хоёрдугаар бүлэг. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн дундаж биелэлт 99 хувь

В. Гуравдугаар бүлэг. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн дундаж биелэлт 86,67 хувь

Г. Дөрөвдүгээр бүлэг. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын дундаж биелэлт 95 хувь

Д. Тавдугаар бүлэг. Бусад мэдээллийн дундаж биелэлт 95 хувь буюу нийт ажлын дундаж биелэлт 92,9 хувьтай байна.

**Тусгагдсан зорилт:** Техникийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлын хүрээнд ТББК-ийг 90 хувиас бууруулахгүй ажиллах, техникийн сааталтай цагийг багасгаж, замд эвдэрсэн тэрэгний тоог бууруулж ажиллах.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Нийт хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан ба ТББК 89,83 хувь, техникийн сааталтай цаг 111 цаг болсон.

**Хүрсэн үр дүн:** ТББК өмнөх оноос 0,88 хувиар дээшилж 89,83 хувь болсон, техникийн сааталтай цагийн тоо өмнөх оны мөн үеээс 374,15 цагаар буурсан, замд эвдэрсэн тэрэгний тоо өмнөх оны мөн үеээс 26-аар буурсан үзүүлэлттэй байна. Зорилтоо биелүүлсэн.

“Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598-2011, “Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо” MNS 4601-2011 Улсын стандарт шаардлагуудыг хангаж ажиллах

Цаг үеийн шинжтэй, цахилгаан автобусны парк шинэчлэлтэй холбоотой ажлууд, онлайн хяналтын цахим тоног төхөөрөмжийн ажиллагааг хянах, ашиглах, хамтран ажиллах тал дээр байгууллагын ИТА-нуудыг татан оролцуулж дадлагажуулах шаардлага гарч байна.

Баазуудад сэлбэггүйгээс тээврийн хэрэгсэл удаан хугацаанд зогсч болзошгүй тул сэлбэг материалын хангалтыг хэлтэс албад хоорондоо уялдаж шуурхай зохицуулалт хийж хангах, удаан хугацаагаар тээврийн хэрэгсэл зогсоохгүй байх шаардлагатай байна.

ТХ-ийн ИТА нар дээд газраас үүрэг болгосны дагуу стандартын хүрээнд албан бичиг, төлөвлөгөө, тайланг хийж хэрэгжүүлэх, тайлагнах шаардлагатай гэж үзэж байна. Цаашид Нэгтгэлийн бусад нэгж албадтай нягт уялдаа холбоотой ажиллаж аваар осолгүй, ажлын байрны таатай орчинг бүрдүүлж ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Тайлан боловсруулсан. Ерөнхий инженер, ТХэлтсийн дарга:

Б.ЭНХЦАГ